

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ХЭЛТЭС, АГЕНТЛАГ, СУМДЫН
2022 ОНЫ 10 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

2022.11.04

Сүхбаатар сум

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй “ХҮНСНИЙ ХАНГАМЖ АЮУЛГҮЙ БАЙДАЛ” үндэсний хөдөлгөөний нээлт манай аймагт боллоо.

Нээлтийн үйл ажиллагаанд МУ-ын Ерөнхийлөгчийн Үйлдвэр, үйлчилгээний бодлогын зөвлөх, Ч.Даваабаяр, ЕТГ-ын Хүнсний төсөл, хөтөлбөр хариуцсан албаны хүнсний мэргэжилтэн А.Амаржаргал, ХХААХҮЯ-ны Газар тариалангийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ, ЭЗХЯ-ны Бүс нутаг, аж үйлдвэрийн бодлогын газрын дарга Д.Эрдэнэбаяр, Зээлийн батлан даалтын сангийн Батлан даалтын газрын дарга А.Амаржаргал, ЭЗХЯ-ны Бүс нутаг, аж үйлдвэрийн газрын мэргэжилтэн Н.Ариунтуяа нарын албаны хүмүүс, үйлдвэрлэгчид, ард иргэд, төр төсвийн байгууллагын ажилтан албан хаагчдын төлөөлөл оролцлоо.

Нээлтийн арга хэмжээний үеэр МУ-ын Ерөнхийлөгчийн Үйлдвэр, үйлчилгээний бодлогын зөвлөх, Ч.Даваабаяр Улсын Их Хурлаас баталсан “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 36 дугаар тогтоолын Бодлого арга хэмжээний хөтөлбөрийг аймгийн Засаг дарга Н.Лхагвадоржид хүлээлгэн өгч Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй “ХҮНСНИЙ ХАНГАМЖ АЮУЛГҮЙ БАЙДАЛ” үндэсний хөдөлгөөнд Сэлэнгэчүүд магнайлан оролцоно гэдэгт итгэл дүүрэн байгаагаар илэрхийллээ.

Нээлтийн хүрээнд “Сэлэнгэ-Алтан намар 2022” нэгдсэн арга хэмжээ аймгийн төв Сүхбаатар суманд зохион байгуулж, үзэсгэлэн худалдаанд аймгийн хүнсний хангамжийг бүрдүүлэгч хүнсний ногоо, жижиг, дунд үйлдвэрлэл, өрхийн аж ахуй эрхлэгчид, тарьц суулгац тариалагчдын төлөөлөл болох 16 сум 6 тосгоны 127 аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөл 30 нэр төрлийн бүтээгдэхүүнээр оролцож 87,2 сая төгрөгийн борлуулалтыг хийлээ.

Энэхүү арга хэмжээ нь үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүн борлуулалтыг нэмэгдүүлэх, ард иргэдийн хэрэгцээг хямд үнэтэй, чанартай, эрүүл экологийн цэвэр бүтээгдэхүүнээр хангах, аж ахуй нэгж, иргэдийн бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлах, худалдааны түншлэл тогтоож харилцан туршлага солилцох үндсэн зорилготой уламжлалт арга хэмжээ юм.

Аймгийн Засаг дарга Н.Лхагвадорж Австралийн Элчин сайдын яамны Консул Эйдан Борхэм, Консулын газрын ажилтан Я.Ижилмөрөн нарыг хүлээн авч санал солилцлоо. Манай аймаг Австрали Улстай боловсролын салбарт амжилттай хамтран ажиллаж байгаа ба бусад салбар чиглэлийн хамтын ажиллагааг өргөжүүлж ажиллах хүсэлттэй байгаагаар илэрхийлэв.

Аймгийн Засаг дарга Н.Лхагвадорж хэлтэс, агентлагийн удирдлагуудтай уулзаж байгууллага тус бүрийн цаг үеийн ажил үйлчилгээний мэдээлэл, тулгамдаж байгаа асуудлыг сонсож, үүрэг чиглэл өглөө.

Манай аймагт Эрчим хүчний зохицуулах хорооны дарга Э.Түвшинчулуун ажиллаж, “Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ-ын хамт олны хийж хэрэгжүүлж байгаа ажил, орчин нөхцөлд маш их шинэчлэлт хийгдсэн байгааг сайшаан цаашид боломжтой бүхий л хэлбэрээр дэмжиж ажиллахаа илэрхийллээ.

Аймгийн Засаг даргын хувьд халаалт дулаанаар хангагч зарим байгууллагуудын “Халаахгүй-Хөлдөөхгүй” гэсэн зарчмыг бүр мөсөн арилгахаар ажиллаж байгаа юм.

Сэлэнгэ аймаг “Гадаад харилцааг эдийн засагжуулах нь” хөтөлбөрийн хүрээнд салбар бүрд олон ажил арга хэмжээг амжилттай хэрэгжүүлж байгаа. Тус хөтөлбөр өргөн цар хүрээнд амжилттай хэрэгжиж байгаа салбар бол боловсролын салбар. Тус салбарт гадаадын хөрөнгө оруулалтаар тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийх, багш, сурагч солилцоо, харилцан туршлага судалж дадлагажих гээд олон ажил арга хэмжээ шат дараатайгаар хэрэгжиж байна.

Дээрх хөтөлбөрийг эдийн засагжуулах ажлын хүрээнд аймгийн Засаг дарга Н.Лхагвадорж БНБУ-ын тэргүүн Алексей Самбуевич Цыденовтой 2 удаагийн хэлэлцээр хийж, боловсрол, соёл, эрүүл мэнд, худалдаа, эдийн засаг, хүмүүнлэгийн салбарт хамтран ажиллахаар тохиролцсон. Энэ удаа ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад Улсын Боловсрол, шинжлэх ухааны сайдын үүргийг орлон гүйцэтгэгч Поздняков Валерий Анатольевич тэргүүтэй боловсролын байгууллагын төлөөлөгчид манай аймагт албан айлчлал хийж аймгийн боловсролын салбарынхантай хамтран ажиллах чиглэлээр уулзалт зохион байгууллаа.

Мөн аймгийн Засаг дарга Н.Лхагвадорж БНСУ-ын Жэжү тусгай мужийн Боловсролын газрын төлөөлөгчдийг хүлээн авч уулзлаа. Жэжү муж нь манай аймгийн боловсролын салбарт онцгой хувь нэмэр оруулж, аймгийн төв Сүхбаатар сумын 1, 2, 4, Шаамар, Цагааннуур сумдын ерөнхий боловсролын сургуулиудад тус бүр 170 сая төгрөгийн хөрөнгө оруулалт бүхий иж бүрэн мэдээлэл технологийн сургалтын танхимыг байгуулж өгөөд байгаа юм.

Америкийн Нэгдсэн Улсын Элчин сайдын яамны консулын ажилтнууд болох Кимберли Гүүдэнкауф, М.Нандинцэцэг, Л.Онон нар манай аймагт ажиллаж, аймгийн Засаг даргын орлогч Ж.Сайнцогтой уулзан санал солилцлоо. Уг айлчлалын хүрээн төрийн албан хаагчдад АНУ-д сурах болон ажиллах визийг хэрхэн мэдүүлэх, юунд анхаарах талаар мэдээлэл өгч, сургалт зохион байгууллаа.

БНСУ-ын Дангжин хотын Засаг дарга У Сон Хуан, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Ким Дог Жү тэргүүтэй тус хотын төлөөлөгчид Сэлэнгэ аймгийн ИТХ-ын дарга Б.Нарантуяа, Засаг дарга Н.Лхагвадорж нартай уулзаж Сэлэнгэ аймаг болон БНСУ-ын Дангжин хот хоорондын түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлж газар тариалан, эдийн засаг, нийгэм, соёл, хүмүүнлэгийн салбар, чиглэлээр хамтран ажиллахаар тохиролцож, БНСУ-ын Дангжин хотод Сэлэнгэ аймгаас улирлын гэрээт ажилтан нийлүүлэх гэрээний төсөлд гарын үсэг зурлаа.

Аймгийн Засаг дарга Н.Лхагвадорж ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад Улсын нийслэл Улаан-Үүд хотод шинээр ашиглалтад орж буй Цөмийн энергийн хавдрын эмнэлгийн нээлтийн үйл ажиллагаанд урилгаар оролцлоо. Энэ үеэр аймгийн Засаг дарга Сэлэнгэ аймгийн иргэдийг тус эмнэлгийн үзлэг оношилгоонд хөнгөлөлттэй үнээр хамруулах, хамтын ажиллагааны хүрээнд олон талт арга хэмжээ зохион байгуулахаар санал солилцон эрүүл мэндийн салбарт хамтран ажиллахаар тохиролцлоо.

“Хавдар судлалын тулгамдсан асуудал-2022” 16 дах удаагийн эрдэм шинжилгээний хурал Улаанбаатар хотноо болж, энэ үеэр Сэлэнгэ аймаг хорт хавдраас урьдчилан сэргийлж эрт илрүүлэх, тусламж үйлчилгээний төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд “Хавдрын цогц тусламж үйлчилгээг орон нутагт хөгжүүлж, жишиг төв бий болгох” хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурлаа.

Хойд бүсийн аймгуудын төр, Улаан загалмайн хамтын ажиллагааны зөвлөлийн туршлага солилцох уулзалт манай аймагт боллоо. Уулзалтад Сэлэнгэ, Дархан-Уул, Орхон, Булган, Хөвсгөл аймгуудын төр, улаан загалмайн хамтын ажиллагааны зөвлөлийн дарга, гишүүд, МУЗН-ийн ерөнхий нарийн бичгийн даргын орлогч, дунд шатны хороодын дарга нар оролцож өөрсдийн аймагт хийж хэрэгжүүлж буй шинэлэг ажлуудаасаа танилцуулж, харилцан мэдээлэл солилцон, туршлагаа хуваалцлаа.

МУЗН-ээс сүүлийн 3 жилд 5,5 тэрбум төгрөгийн хүмүүнлэгийн тусламж үзүүлснээс Сэлэнгэ аймагт 200 гаруй сая төгрөгийн хүмүүнлэгийн тусламж үзүүлээд байгаа юм.

Алтанбулаг суманд Олон Улсын стандартад нийцсэн мах махан бүтээгдэхүүнийг “Хүч Агро” ХХК нь үйлдвэрлэн, “Органик фермээс шууд таны гар дээр” уриатайгаар 16 нэр төрлийн СТЕЙК-ийг орчин үеийн сав баглаа боодолтойгоор худалдаанд гаргаж байна.

Сэлэнгэ аймагт зохион байгуулагдсан төрийн албаны ерөнхий шалтгалтад нийт оролцох 156 оролцогчоос 124 иргэн оролцож, ирц 79,49 хувьтай, үүнээс 32 иргэн тэнцэж нөөцөд бүртгэгдэх боломжтой боллоо.

Аймгийн Онцгой комиссын үйл ажиллагааны талаар:

Аймгийн Онцгой комиссын даргаас хийж хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний талаар өгсөн үүрэг чиглэл, мэргэжлийн байгууллагуудаас хэрэгжүүлсэн арга хэмжээ, нөхцөл байдлын мэдээллийг хүлээн авч холбогдох шийдвэрийг гарган сумдын Онцгой комиссын дарга нарт үүрэг чиглэл хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

“Коронавируст /Ковид-19/-ын халдварт цар тахлаас урьдчилан сэргийлэх талаар аж ахуйн нэгж, байгууллагуудад дагаж мөрдөх журам”-ын хүрээнд аж ахуйн нэгж, байгууллагуудад халдвар хамгааллын дэглэмийг сахиулж, ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хийлгэн журмыг мөрдүүлэн ажиллаж байна.

Шуурхай штабын **70363684, 70360119** дугаарын утсанд мэдээллийг хүлээн авч, аймгийн болон холбогдох байгууллагуудын цахим хуудсаар дамжуулан заавар, зөвлөгөө, мэдээ, мэдээллийг тогтмол байршуулж байна. Коронавирусын эсрэг 18 төрлийн мэдээлэл, сургалт сурталчилгааг цахим хэлбэрээр нийт 6958 хүнд хүргэсэн бөгөөд бусдад хуваалцсан 285, дэмжсэн 458 иргэн байна.

Аймгийн хэмжээнд коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын 1 дүгээр давлагаанд **217**, 2 дугаар давлагаанд **4849**, 3 дугаар давлагаанд **13783**, 4 дүгээр давлагаанд **10043** нийт батлагдсан тохиолдол **28884** байна. Дотоодын нийт халдварын 30.8 хувь (8885) нь аймгийн төвд 69.2 хувь (19999) нь бусад орон нутагт бүртгэгдсэн. 2022 оны 10 дугаар сарын байдлаар нийт 11 батлагдсан, бүгд түргэвчилсэн шинжилгээгээр батлагдсан байна. Үүнээс 0-17 насны хүүхэд өвдөөгүй байна. Аймгийн хэмжээнд 2 эмнэлгийн 2 тасагт 1 хүн эмчлэгдсэн гэрээр аймгийн хэмжээнд 3 сум, тосгонд 10 иргэнийг өрх болон сум, тосгоны Эрүүл мэндийн төвийн хяналтад эмчилсэн бөгөөд өнөөдрийн байдлаар Мандал суманд 3, Сүхбаатар 1, Орхонтуул 1 тохиолдол байна. Тасаг болон гэрийн эмчилгээнээс өссөн дүнгээр нийт 28829 иргэн эдгэрсэн байна. (Ковид-19) халдварын нас баралт 62 байгаа бөгөөд энэ сард нас баралт гараагүй байна.

Дархлаажуулалтад өссөн дүнгээр I тун **70473**, II тун **66438**, III тун **37462**, IV тун **7216** тус тус хийгдээд байна.

Онцгой байдлын ажил үйлчилгээний талаар:

Тайлант хугацаанд объектын гал түймрийн 6, ой, хээрийн гал түймрийн 1, эрэн хайх 1, усны ослын 1, аврах ажиллагааны 4 нийт 13 удаагийн гамшиг осол, гал түймрийн дуудлагаар гарч иргэн, аж, ахуйн нэгж байгууллагын 250,000,000 сая төгрөг ий нөмч хөрөнгийг гал түймрийн аюулаас авран хамгаалсан байна.

Монгол Улсын Шадар сайдын баталсан “Гамшгийн эрсдэлийг бууруулах олон улсын өдөр”-ийг аймгийн Улаан загалмайн хороо, “Дэлхийн Зөн Монгол” ОУБ-ын Сэлэнгэ нутгийн хөтөлбөртэй хамтран зохион байгуулж, “Онцгой байдлын цаг” нэвтрүүлэг бэлтгэн 17 сум 6 тосгоны цахим хуудсанд байршуулан олон нийтэд хүргэсэн. Өдөрлөгийн хүрээнд Баянгол, Мандал, Сайхан, Сүхбаатар, Хүдэр сумын 529 гэр хорооллын айл өрхийн 1645 иргэн, олон нийтийн газарт үйлчилгээ авч байсан 1051 иргэнд болзошгүй гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх ухуулга, сурталчилгааны ажлыг зохион байгуулж, 8 төрлийн сэрэмжлүүлэг анхааруулга санамжийг өгсөн.

Онцгой байдлын байгууллагын үйл ажиллагаа болон Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хуулийг сурталчлах өдөрлөгийн арга хэмжээг Баянгол, Мандал, Сайхан, Сүхбаатар, Хүдэр суманд 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулсан.

2022 оны 10 дугаар сард 2 гал гарсан гэх дуудлага мэдээллийг шалгаад зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж Зөрчлийн тухай хуулийн дагуу 100 нэгж буюу 100,000 төгрөг (нэг зуун мянга)-ийн торгуулийн арга хэмжээ авсан.

Урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг материал, зөвлөмжийг “Объектын гал түймрээс урьдчилан сэргийлье”, “Газар хөдлөлтийн үед авах арга хэмжээ”, “Хүүхдийн аюулгүй орчныг бүрдүүлье” сэдвээр бэлтгэн 158 иргэнд тарааж ажиллалаа.

Хяналт шалгалтын ажлын мэдээг нэгтгэсэн дүн:

Ш	ал	Ай	г	Зөрчил	Захиргааны арга хэмжээ	З	а	в	Ал	Т	а	Аж	ил	О	у	р	г	ал	г	д	а	л	л	Х	в
---	----	----	---	--------	------------------------	---	---	---	----	---	---	----	----	---	---	---	---	----	---	---	---	---	---	---	---

		Илэрүүлсэн зөрчлийн тоо	Шалгалтын явцад арилгуулсан зөрчлийн тоо	Арга хэмжээ авагдсан субъектын тоо	Торгуулийн хэмжээ /төгрөгөөр/						
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
30	27	690	204	2	200,0	25	1 2	-	-	6 сургалт, 1 дадлага 291 ажилтанд зааварчилгаа өгч ажилласан	8

Тайлант үед 1 байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулж зөрчлийг арилгасан 1 объектод ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт олгож 12,500, төрийн болон төрийн бус аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн барилга байгууламжийн 1 ажлын зургийг хянаж дүгнэлт гарган холбогдох байгууллагад хүргүүлэн 50.000 төгрөгийн хураамжийг сумын төрийн сангийн дансанд төвлөрүүлсэн.

Мэргэжлийн хяналтын үйл ажиллагааны талаар:

Аймгийн Засаг даргын 2022 оны “Малд зохиомол хээлтүүлгийн үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулах тухай” захирамжийн хэрэгжилтэд хяналт тавих ажлаар Алтанбулаг, Шаамар, Сүхбаатар суманд мал бүхий иргэн, аж ахуйн нэгжийн үнээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар зохиомол хээлтүүлэг хийх ажлыг гүйцэтгүүлэхээр Алтанбулаг сумын “Чагтай” ХХК-ий 114 үнээ, “Тэргүүн тэлмэн” ХХК-ий 45 үнээнд Герефорд үүлдрийн бухын үрээр, “Хүчү агро” ХХК-ий 65 үнээнд Ангус үүлдрийн бухын гүн хөлдөөсөн үрээр, Шаамар суманд 400 үнээнд зохиомол хээлтүүлэг хийхээс 1 аж ахуйн нэгж, 37 иргэний 246 үнээнд, Сүхбаатар суманд 200 үнээнд зохиомол хээлтүүлэг хийхээс 33 мал бүхий иргэний 189 үнээнд Симменталь, Алатау, Герефорд, Ангус үүлдрийн бухын гүн хөлдөөсөн үрээр тус тус зохиомол хээлтүүлгийн ажлыг хийж гүйцэтгэсэн нь хээлтүүлгийн журнал, 6А маягтын хөтлөлт, малчинд зохиомол хээлтүүлэг хийсэн тухай баримт материалаар тодорхойлогдож байна. Нийт 3 сумын 800 үнээнд зохиомол хээлтүүлэг хийхээс 79,4 хувь буюу 635 үнээнд зохиомол хээлтүүлэг хийсэн ажлын гүйцэтгэлтэй байна.

Үнээний хээлийн шалгалтыг шулуун гэдэсний аргаар шалгахад Баруунбүрэн суманд 70 хувь, Орхон суманд 70 хувь, Орхонтуул суманд 73 хувь, Сант суманд 65 хувь, Сайхан суманд 65 хувийн үзүүлэлттэй байна.

Стандарт, хэмжил зүйн үйл ажиллагааны талаар:

Сүхбаатар, Мандал, Хүдэр, Ерөө сум, Бугат тосгонд үйлчилгээний баталгаажуулалтыг хийж **13** иргэн, аж ахуйн нэгжийн **4** минимаркет, **1** ая тухтай дэлгүүр, **3** хүнсний дэлгүүр, **1** хүнсний мухлаг, **2** зоогийн газар, **1** түргэн хоолны газар, **1** цайны газар, **1** зочид буудал, 12 баар нийт **15** үйлчилгээний газарт “Жижиглэн худалдааны газар, түүний үйлчилгээ. Ерөнхий шаардлага MNS 5021-

1:2019”, “Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт тавих шаардлага MNS 4946:2019”, “Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ - Зочид буудалд тавих ерөнхий шаардлага MNS 4588 : 2008” стандартын шаардлагын дагуу тохирлын үнэлгээ хийж, тохирлын гэрчилгээг 1-2 жилийн хугацаагаар сунгалаа.

Ерөө суманд үйл ажиллагаа явуулдаг 3 аж ахуйн нэгжид экспорт баталгаажуулалт хийж 65 экспортын гэрчилгээ олгосон.

Стандарт, мэдээллийн салбар сангаас 3 аж ахуй нэгж, байгууллага иргэний захиалгын дагуу 38 нэрийн 39 стандартын борлуулалт хийж, мэдээлэл арга зүйн зөвлөмж өгч ажилласан.

Сүхбаатар сумын худалдаа, үйлчилгээ, үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагаанд “Хэмжилзүйн тухай” хуулиудын хэрэгжилтийг хангуулах үүднээс ашиглагдаж буй хэмжих хэрэгслийг баталгаажуулалтад хамруулах ажлыг хийсэн.

Эзлэхүүн хэмжлийн төрлөөр: Хүдэр, Ерөө сумдад 30 жин шалгалт баталгаажуулалт, эзлэхүүн-2 ШТС-ын 9 түгээгүүр баталгаажуулсан байна.

Шалган тохируулгаар: 2 байгууллагын лабораторийн 6 электрон жин, 8 туухай, 2 шилэн хэмжүүрт шалгалт тохируулга хийсэн.

Цахилгаан хэмжлийн төрлөөр: Дархан-Уул аймгийн Дархан суманд 1 фазын 1200 ширхэг тарифт электрон, Сүхбаатар сумын хэрэглэгчийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй 1 ба 3 фазын 6 ширхэг цахилгааныг тоолуурыг шалган ээлжит баталгаажуулалтад хамруулсан.

Хоёр. Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:

Тус сард 736 баримтаар 10.6 тэрбум төгрөгийн төсөвт байгууллагуудын төлбөр тооцоог хянан гүйцэтгэлээ.

Аймгийн 09 дүгээр сарын төсвийн гүйцэтгэлийн нэгдсэн мэдээг гаргаж Статистикийн хэлтэст хугацаанд нь хүргүүлж, мөн сарын аймгийн орлогын гүйцэтгэлийн мэдээг Татварын хэлтэстэй тулган баталгаажуулж, төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр аймгийн цахим хуудас, шилэн данс болон ил тод байдлын самбарт байршуулан ажиллаж байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг сум бүрд хуваарилан тавьж, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт олгосон.

1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:

д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1.	Орон нутгийн төсвийн нийт орлого	55,234,938.7	47,536,193.4	86.1
	Орон нутгийн төсвийн орлого	37,667,634.0	32,497,164.6	86.3
1.1	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	15,664,382.4	10,823,148.3	69.1
	Сумдын төсвийн орлого	22,003,251.6	21,674,016.3	98.5
1.2	Сумдаас авах орлогын шилжүүлэг	3,241,514.1	2,428,798.9	74.9
1.3	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг	9,141,160.9	8,824,738.4	96.5
1.4	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн орлого/	954,453.9	954,453.9	100.0
1.5	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн хөгжлийн сан/	2,059,334.5	2,059,334.5	100.0
1.6	Сум хөгжүүлэх сангийн орлого	1,959,197.7	488,479.7	24.9
1.7	Төсөвт байгууллагын өөрийн орлого	211,643.6	283,223.4	133.8

2. Орон нутгийн төсвийн нийт зарлага		55,234,938.7	40,885,240.8	74.0
2.1	Орон нутгийн төсвийн нийт зарлага	55,234,938.7	40,885,240.8	74.0
	Үүнээс: Сумдын орон нутгийн байгууллагуудын зарлага	21,769,383.9	20,190,646.9	92.7
	Сумдын орон нутгийн хөгжлийн сан	12,896,096.3	4,884,724.9	37.9
	Аймгийн шууд харьцдаг байгууллагуудын зарлага	20,569,458.5	15,809,868.9	76.9
	Үүнээс: Аймгийн төсвийн хөрөнгө оруулалт	4,479,713.2	3,262,503.3	72.8
	Аймгийн орон нутгийн хөгжлийн сан	5,623,572.1	3,392,232.7	60.3
	Халамжийн сан	138,020.0	84,722.1	61.4
	Шууд харьцдаг төсвийн байгууллагуудын зарлага	9,278,153.2	8,321,386.6	89.7
	Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө	1,050,000.0	749,024.2	71.3
3. Аймгаас олгосон санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг		14,667,877.1	14,351,454.6	97.8
3.1	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	5,526,716.2	5,526,716.2	100.0
3.2	Сумдад олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	5,220,488.8	5,220,488.8	100.0
	Үүнээс: Хот тохижуулахын урсгал зардалд	106,006.5	106,006.5	100.0
	Мал эмнэлгийн үйлчилгээний зардалд			
	Хөрөнгө оруулалтын зардалд	5,114,482.3	5,114,482.3	100.0
3.3.	Аймагт олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	3,920,672.1	3,604,249.6	91.9
	Үүнээс: Хөрөнгө оруулалтын зардалд	3,523,572.1	3,207,149.6	91.0
	Мал эмнэлгийн үйлчилгээний хяналтын зардалд	375,449.4	375,449.4	100.0
	Усан хангамжийн татаас	21,650.6	21,650.6	100.0
4. Тусгай сангуудын зарлага		1,959,197.7	488,479.7	24.9
4.1	Сумдын сум хөгжүүлэх сан	1,959,197.7	488,479.7	24.9

2.Өргөн хэрэглээний барааны үнэ:

Өргөн хэрэглээний барааны нэр төрөл		2021 - IX	2022 – IX	<u>2022-IX</u> <u>2021-IX</u>
1.ХҮНСНИЙ БАРАА				
1	Талх, гурил, будаа	1 650	1 600	97.0
	Гурил /Алтантариа, I зэрэг, кг/	1 400	1 500	107.1
	Талх /орон нутгийн, ш/	4 000	5 000	125.0
	Нарийн боов /кг/	2 700	3 500	129.6
	Будаа /кг/	2 400	3 300	137.5
	Элсэн чихэр /кг/			
2	МАХ МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН			
	Хонины мах /кг/	8 800	8 500	96.6

	Үхрийн мах /кг/	9 800	10 500	107.1
	Адууны мах /кг/	7 500	8 000	106.7
	Ямааны мах /кг/	7 500	8 000	106.7
	Дотор мах, цувдай /цусгүй/	5 000	7 000	140.0
	Хиам /чанасан, кг/	12 500	17 100	136.8
3	СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ			
	Сүү /задгай, л/	1 200	1 300	108.3
	Сүү / савласан, л/	3 200	4 800	150.0
	Тараг /задгай, л/	1 300	2 000	153.8
	Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/	21 000	25 000	119.0
	Айраг /л/	5 000		
	Хуурай сүү /кг, Орос, 25% тослогтой/	4 500	6 600	146.7
	Өндөг /ш/	350	400	114.3
4	Бүх төрлийн өөх тос			
	Ургамлын тос /л/	5 300	11 000	207.5
	Өөхөн тос /кг/	2 800	3 000	107.1
	Шар тос /кг/	20 000	25 000	125.0
	Масло /задгай, кг/	4 700	7 500	159.6
5	ХҮНСНИЙ НОГОО			
	Төмс /кг/	1 500	2 000	133.3
	Лууван /кг/	2 400	2 500	104.2
	Манжин /кг/	2 100	2 500	119.0
	Байцаа /кг/	1 200	2 500	208.3
	Сонгино /кг/	2 500	2 800	112.0
	Өргөст хэмх /шилтэй, дарсан/	5 500	7 500	136.4
	Алаг салат /шилтэй, Urbanek, 630гр/	4 700	5 250	117.7
2. ШАТАХУУН				
	Бензин А - 80	2 040	2 480	121.6
	Бензин А - 92	2 070	2 500	120.8
	Дизелийн түлш	2 490	4 030	161.8

Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

Сүхбаатар сумын хүрээнд өрнөж буй “Шударга удирдагч, шударга төрийн албан хаагч” аяны хүрээнд сургууль цэцэрлэгүүдээр “Авилгын эсрэг хууль, Хувь хүний мэдээллийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Авилгын хор хөнөөл” сэдвүүдээр сургалтыг зохион байгуулсан.

Улсын бүртгэлийн хэлтэс: 10 дугаар сарын иргэний бүртгэлийн талаар

- Төрсний бүртгэл - 144 /эрэгтэй-79, эмэгтэй-65/
- Гэрлэлтийн бүртгэл - 44
- Гэрлэлт цуцалсны бүртгэл - 9
- Үрчлэлт - 3
- Эцэг тогтоолт - 13
- Овог эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл - 7

- Нас баралт - 48
- Нийт олгосон иргэний үнэмлэх - 290
- Шинээр олгосон иргэний үнэмлэх - 116
- Дахин олгосон иргэний үнэмлэх - 46
- Иргэний үнэмлэхийн хугацаа дуусаж авсан - 132
- Гадаад паспорт олголт - 2332
- Аймаг хотоос бүр мөсөн шилжин ирсэн - 176
- Хот доторх шилжилт хөдөлгөөн - 178 тус тус бүртгэгдсэн байна.

Газар өмчлөх, эзэмшиг, ашиглах эрхийн улсын бүртгэлийн талаар:

- Хүлээн авсан мэдүүлгийн тоо - 5374
- Анхны бүртгэл - 390
- Өмчлөх эрх шилжих гэрээ - 882
- Барьцааны гэрээ - 3813
- Бүртгэлд өөрчлөлт оруулах - 117
- Лавлагаа хуулбар - 52
- Нийт бичигдсэн гэрчилгээний тоо - 1361

Цагдаагийн газар: Аймгийн хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээ урьдчилсан байдлаар

Д/д	Үзүүлэлт	2021.10	2022.10	Өсөлт, бууралт	Хувь
1	Нийт бүртгэгдсэн гомдол мэдээлэл	2898	3432	534	18.4 хувиар өссөн
	Үүнээс: Гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл	1029	1293	264	25.6 хувиар өссөн
	Үүнээс: Зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл	1869	2139	270	14.4 хувиар өссөн
2	Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг	535	669	134	25.0 хувиар өссөн
3	Нийт бүртгэгдсэн зөрчил	16858	27199	10341	61.3 хувиар өссөн

Архивын тасаг: Төрийн архивын тасгаас 2022 онд хийх “Архив, албан хэрэг хөтлөлтийн хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө”, сургалтын төлөвлөгөөний дагуу Мандал, Баянгол сумын Засаг даргын Тамгын газар, Мандал сумын Хэрх, Түнхэл тосгоны захирагчийн албаны архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг шалгаж, төр, төсвийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтнууд болон албан хаагчдад сургалт зохион байгуулж, заавар зөвлөгөө өгч ажилласан.

Төрийн архивын мэдээллийн нэгдсэн санг үүсгэн, архивын үйл ажиллагааг хурдан шуурхай, баталгаатай, олон талт, хүртээмжтэйгээр цахим тогтолцоог үүсгэх зорилгоор e-document.gov.mn программыг Архивын ерөнхий газраас 2022 оны 1 дүгээр улиралд салбарын хэмжээнд шинээр нэвтрүүлсэнтэй холбогдуулан тус архивын 174 хөмрөгийн бүртгэл, хөмрөгийн нэрийн өөрчлөлт, байгууллагын

бүртгэл, байгууллагын нэрийн өөрчлөлт, зохион байгуулалтын бүртгэл, зохион байгуулалтын нэгжийн өөрчлөлт зэргийг оруулсан.

Архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд Хөтөлийн “Цемент шохой” ХК, 12 хадгаламжийн нэгжийн 2763 хуудас баримтын агуулгыг уншиж заалт 1743, хүний нэр 24347, байгууллагын нэр 937, газар зүйн нэр 120 шивж, эх баримттай холбох ажлыг хийж гүйцэтгэсэн.

Дөрөв. Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:

Аймгийн 17 сум 6 тосгон болон Төр захиргааны байгууллагын төрийн албан хаагч, аж ахуй нэгж байгууллагын нийт 80 иргэнд “Шидэт гар” дохионы хэлний анхан шатны сургалтыг зохион байгуулж, аймгийн Засаг даргын 2022 оны А/417 тоот захирамжаар 4.6 сая төгрөгийг шийдвэрлэсэн.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвтэй хамтран Эрүүл мэндийн салбарын эмч сувилагч, сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургуулийн багш нарт “Хөгжлийн бэрхшээлтэй хоцрогдолтой хүүхдүүдэд үзүүлэх тусламж, эрт илрүүлэг, арга зүйн дэмжлэг үзүүлэх” сургалтыг зохион байгуулж нийт 50 гаруй албан хаагч хамрагдаж аймгийн Засаг даргын 2022 оны А/396 тоот захирамжаар 1.5 сая төгрөгийг шийдвэрлэж ажиллалаа.

Боловсрол, соёл урлаг, спортын талаар: Аймгийн хэмжээнд Дизайн технологийн багш нарт “Суралцахуйн үр дүн ба үнэлгээ” сэдвийн доор хэлэлцүүлэг өрнүүлж, онлайн сургалт зохион байгуулж бүлэг, нэгж хичээлийн үнэлгээ хийх арга аргачлалын заавар, чиглэл өгч нийт 37 багш хамрагдсан.

Мандал сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн англи хэлний багш Д.Оюунтуяа "Task Based Language Teaching" буюу "Хэрэглээнд суурилж хэл заах арга зүй" сэдэвт сургалтыг АНУ-ын элчин сайдын яамны санхүүжилтээр Хараа болон Бэлчир бүсэд зохион байгуулж 31 багш хамрагдсан.

Суралцагчийн мэдлэг, чадварын түвшинг үндэсний түвшинд тогтоох, сурлагын амжилтад нөлөөлж буй хүчин зүйлийг судлах, боловсролын бодлогын хэрэгжилтийг үнэлэхэд чиглэсэн бага, дунд боловсролын чанарын үнэлгээний судалгаат шалгалтыг ерөнхий боловсролын 3 сургууль, 1 мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, Политехник коллежийн 6,10, 12 дугаар ангийн сурагчдаас авч, асуулга судалгаанд хамруулж, орчны судалгаа, фокус ярилцлагыг зохион байгуулсан.

Монголын багш нарын 56, дэлхийн багш нарын 28 дахь өдрийн баярын хурал, арга хэмжээг зохион байгуулж боловсролын салбарт олон жил үр бүтээлтэй ажилласан багш, ажилтнуудын гавьяа зүтгэлийг үнэлж төрийн дээд одон медаль болон салбарын шагналаар шагнасныг гардуулан өглөө.

- “Алтан гадас” одонгоор 1 ахмад багш,
- Засгийн газрын шагнал “Боловсролын тэргүүний ажилтан” тэмдгээр 19,
- Боловсрол, шинжлэх ухааны “Жуух бичиг”-ээр 37,
- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Хүндэт өргөмжлөл”-өөр 3,
- Аймгийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр 2,
- Боловсрол, шинжлэх ухааны газрын шагнал “Арга зүйч багш” тэмдгээр 149, “Ахлах багш” тэмдгээр 102, “Багшийн алдар” тэмдгээр 97, “Бүтээлч багш” тэмдгээр 19, “Шилдэг багш” тэмдгээр 14, “Шилдэг менежер” тэмдгээр 6,

“Боловсролын төлөө” тэмдгээр 81, “Ахмадын алдар” тэмдгээр 28, нийт 496 багш, ажилтан албан хаагчдад шагналыг гардуулан өгсөн байна.

“Төрийн удирдлага системт шинжлэх ухаан болох нь” сэдэвт сургалтад 14, “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдэвт сургалтад 9 албан хаагч хамрагдсан. “Суурь боловсролын чанарыг ахиулахад мэдээлэл харилцааны технологийг оновчтой ашиглах нь” төслийн үр дүнгийн асуулга судалгааг МУБИС, JICA төслийн багтай хамтран зохион байгуулж 33 сургуулийн захирал, 34 дунд ангийн сургалтын менежер, 6-9-р ангид хичээл заадаг 662 багш нийт 729 хүн хамрагдсан.

Хүнсний ногоо тарьж, хүнсэнд хэрэглэж буй байдлын судалгааг аймгийн бүх сургууль, цэцэрлэг, мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, коллежоос авч нэгтгэхэд 32 сургууль, 40 цэцэрлэг төмс, хүнсний ногоо тарьж, ургуулж, помидор 706, өргөст хэмх, 1399, салат хавч 175, амтат чинжүү 357, төмс 30331, лууван 33501, манжин 1447, сонгино 730, байцаа 2366, саримс 115 нийт 71127 кг хүнсний ногоо хураан үдийн цай болон дотуур байрны сурагчдын хүнсэнд хэрэглэж байна.

Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны багш нарт зориулсан “Дотуур байран дахь хүүхэд хамгаалал” сэдэвт сургалтын хоёрдугаар шатны сургалт, “Дотуур байрны суралцагчийн эрх, хамгаалал, аюулгүй байдал” сэдэвт уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

Шаамар сум дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн хичээлийн байранд “Хүүхдийн хоолны тогооч нарын мэргэшүүлэх сургалт”-д Ерөнхий боловсролын сургууль, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, Политехник коллежийн багш, тогооч нийт 40 хүн хамруулсан.

Аймгийн хэмжээнд соёлын өвийн нэгдсэн улсын системд бүртгэлд бүртгэлтэй 3391 дурсгалт газруудаас 11 сумын 1600 гаруй дурсгалт газрыг тоолж бүртгэн улсын нэгдсэн санд шинээр оруулан ажилласан.

Байгалийн түүхийн музейнтэй хамтран ажиллах гэрээний дагуу “Байгалийг ойроос” түр үзэсгэлэн зохион байгуулж цэцэрлэгүүдтэй хамтран ажиллаж долоон цэцэрлэгийн 150 гаруй хүүхдүүдэд тайлбартайгаар үнэ төлбөргүй үзүүлсэн.

Мандал сумын харьяат бөхийн чөлөөт барилдааны спортын мастер аймгийн хурц арслан, Ардын боловсролын тэргүүний ажилтан Г.Жаргалтулга агсны нэрэмжит өсвөр үеийн Үндэсний бөхийн барилдаан 11 дэх жилдээ зохион байгуулж тэмцээнд 16 сумын 60 гаруй залуу бөхчүүд хурд, хүч, уран мэхээ уралдуулан барилсан.

➤ Багийн дүнгээр

1-р байранд 40 даваагаар Б.Нямлхагва дасгалжуулагчтай /Баянгол сум/

2-р байранд 35 даваагаар Н.Энхбаяр дасгалжуулагчтай /Хан Хушаат дэвжээ/

3-р байранд 35 даваагаар Д.Оюунтөмөр дасгалжуулагчтай /Биеийн тамир спортын газар/ баг тамирчид эхний 3 байр эзэлсэн байна.

“Ахмадын биеийн тамир”-ыг дэмжих сарын аяныг 7 цогцолборт зохион байгуулж /Мандал, Сайхан, Ерөө, Баянгол, Цагааннуур, Баруунбүрэн сум Дулаанхан тосгон/ өглөөний алхалт, софт волейбол, шатар, даам, шагайн наадгай, дардас, дасгал хөдөлгөөн гэсэн төрлүүдэд 720 гаруй ахмад настан хамрагдсан байна. “Ахмадын биеийн тамир” спортын арга хэмжээг Цагааннуур суманд зохион байгуулж 4 сумын 70 гаруй ахмад тамирчид оролцсон байна.

Эрүүл мэндийн талаар: “Сүрьеэгийн эрт илрүүлэг”-т Хилийн цэргийн 0101-р анги, Гаалийн алба, Гадаадын иргэн харьяатын газрын нийт 198 ажилчдыг хамруулсан бөгөөд цээжний рентген зурагт өөрчлөлттэй 23, үүнээс цэр шинжилгээ өгөх шаардлагатай 2 хүнийг илрүүлсэн байна.

“5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, амьгүй төрөлтийг магадлан хэлэлцэх хурал” зохион байгуулж хурлаар амьгүй төрөлтийн 2, хүүхдийн 2 тохиолдлыг хэлэлцэн, хурлаас гарсан зөвлөмжийг бүх шатны эмнэлгүүдэд хүргүүлэн ажилласан байна. Хуралд нийт 60 эмч, эмнэлгийн мэргэжилтэн цахимаар болон танхимаар оролцсон.

Манай аймагт “LAUREL SURGICAL FOUNDATION” ОУБ, УНТЭ-ийн Нүд судлал, мэс заслын тасгийн эмч, резидент эмч нарын нийт 23 хүний бүрэлдэхүүнтэй баг ажиллаж болрын хагалгаа болон далавч хальсны хагалгаанд орох шаардлагатай иргэдийг давтан үзсэн ба 3 өдрийн үзлэгт 123 хүн хамруулж болрын мэс засал, далавч хальсны мэс засалд 87 хагалгаа хийгдсэн.

Хагалгаанд орсон иргэдийг сумдаар нь авч үзвэл Сүхбаатар 41, Алтанбулаг 5, Баруунбүрэн 3, Ерөө 3, Жавхлант 2, Зүүнбүрэн 4, Мандал 7, Сайхан 5, Түшиг 3, Хушаат 5, Цагааннуур 6, Шаамар 3 иргэн байна.

Хугацаат цэргийн албаны 2022 оны хоёрдугаар ээлжийн эрүүл мэндийн үзлэгийг Мандал, Сайхан, Жавхлант, Сүхбаатар сумдад бүсчлэн зохион байгуулж залуучуудыг 14 төрлийн нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг, 3 төрлийн оношилгоо, 5 төрлийн шинжилгээнд хамруулж 902 залуучууд хамрагдсанаас 28,9 хувь нь эрүүл мэндээр тэнцсэн нь өмнөх таталгаас 16,7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Аймгийн хэмжээнд “Дархлаажуулалтын 10 хоног”-ийн хүрээнд 7, 15 насанд хийгдэх Сахуу, татрангийн товлотт вакциныг зохион байгуулж 7 настай 1800, 15 настай 1200 хүүхдүүдийг сургуулиар дархлаажуулалтад хамруулахаас 2430 хүүхдийг хамруулсан. Хамрагдалт 81 хувьтай байна.

Монгол Улсын Засгийн газрын санаачилгаар зохион байгуулагдаж буй “Хүн амын нас, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох үзлэг, оношилгоо”-г аймгийн 2 Нэгдсэн эмнэлэг, 17 сум 6 тосгон, өрхийн эрүүл мэндийн төвүүдээр зохион байгуулж байна.

Хүн амын нас хүйс, эрсдэлд суурилсан халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэг, оношилгоо шинжилгээнд 113,325 иргэн хамрагдахаас 10 дугаар сарын байдлаар 12904 иргэн хамрагдаж, хамрагдалт 10,9 хувь байна.

Аймгийн Нэгдсэн эмнэлэг, Мандал сумын Нэгдсэн эмнэлэгт насанд хүрэгчдийн буюу 18-аас дээш насны эрт илрүүлэгт 74586 иргэн хамрагдахаас 1882 иргэн хамрагдсан. Хамралт 2,5 хувь байна.

Насанд хүрэгчдийн 4 эрт илрүүлгийн багцад буюу

1. 18-30 насанд 21908 иргэнд хамрагдахаас 1811 иргэн хамрагдсан бөгөөд хамралтын хувь 8,2 хувь

2. 31-45 насанд 24774 иргэнд хамрагдахаас 354 иргэн хамрагдсан бөгөөд хамралтын хувь 1,4 хувь

3. 46-60 насанд 19074 иргэнд хамрагдахаас 240 иргэн хамрагдсан бөгөөд хамралтын хувь 1,3 хувь

4. 61-ээс дээш 8793 иргэнд хамрагдахаас 99 иргэн хамрагдсан бөгөөд хамралтын хувь 1,1 хувь тус тус хамрагдсан байна.

Анхан шатны эрүүл мэндийн байгууллага буюу сум, тосгон, өрхийн эрүүл мэндийн төвд 0-17 насны 38739 хүүхэд эрт илрүүлэг үзлэг оношилгоонд хамрагдахаас 11022 хүүхэд хамрагдсан байна. Хамралтын 28,5 хувь байна.

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, нийгмийн даатгалын хүрээнд: Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж хөнгөлөлтийн үйлчилгээг зорилтот бүлэгт түргэн шуурхай, хүнд сурталгүй чанартай хүргэх ажлын хүрээнд

Халамжийн санд улсын төсвөөс тайлант хугацаанд 74821 иргэнд 52561329.4 мянган төгрөгийг олгоод байна.

Халамжийн санд орон нутгийн төсвөөс тайлант хугацаанд Орон гэрийн хөнгөлөлт, тусламж, Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ, Амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдийн урамшуулал зэрэгт 347 иргэнд 101389.0 мянган төгрөгийг олгоод байна.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээнд 14, идэвхтэй ажил хайгчаар 281, ажил зуучлах үйлчилгээнд 41 иргэн, сул чөлөөтэй 51 ажлын байрыг бүртгэж мэдээлсэн байна иргэн

“Залуу малчин-2022” уулзалт зөвлөгөөн, сүү цагаан идээний үзэсгэлэн худалдаа “Хөдөлмөрийн бүтээмж-2022” үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, үзэсгэлэн худалдаанд хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангаас олгогддог санхүүгийн дэмжлэгт хамрагдсан 17 сумын 110 гаруй иргэн оролцсон.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг хангахад болон байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааг дэмжих, иргэдийн идэвх санаачилгыг нэмэгдүүлэхэд ажилгүй иргэдийн оролцоог хангаж, тэдний орлогыг нэмэгдүүлэх зорилгоор мод тарих, суулгах арга хэмжээнд Мандал, Орхон, Орхонтуул, Сайхан, Хүдэр, Цагааннуур, Баянгол, Сант сумдын ажилгүй, ажил олоход хүндрэлтэй болон нийгмийн халамжийн дэмжлэг зайлшгүй шаардлагатай өрхийн хөдөлмөрийн насны бөгөөд хөдөлмөрийн чадвартай иргэнийг хамруулж, мод тарих аргачлал, ач холбогдлын талаар мэдлэг олгох сургалтад суулган, 110 иргэнийг түр ажлын байранд зуучлан ажлын урамшуулалд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 21613.9 мянган төгрөгийг зарцуулсан байна. Алтанбулаг, Мандал, Орхон, Орхонтуул, Сайхан, Сүхбаатар, Хүдэр, Цагааннуур, Мандал сум, Номгон, Дулаанхан тосгоны байгалийн гамшиг, гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй бусад нөхцөл байдлын улмаас үүссэн хор уршгийг арилгах, нөхөн сэргээх нийтийн эзэмшлийн гудамж зам, талбайд бүтээн байгуулалт хийх, сайжруулах, тохижилт хийх, хог хаягдалгүй байлгах, байгаль орчныг хамгаалах, ой цэвэрлэх, голын ай сав, үер усны даланг цэвэрлэх, гүүр сэргээн засварлах зэрэг үйл ажиллагааг нийтийг хамарсан ажлын хүрээнд зохион байгуулж, ажилгүй болон ажил олоход хүндрэлтэй, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн хөдөлмөрийн насны бөгөөд хөдөлмөрийн чадвартай 229 иргэнийг хамруулж, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 43968.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нийгмийн даатгалын Ерөнхий газраас 4,171,894,300 төгрөгийн санхүүжилт хийгдэж Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө 35627937,40 мянган төгрөг оруулах төлөвлөгөөтэйгөөс 42278156,12 мянган төгрөг хуримтлуулж төлөвлөгөөний биелэлт 118,67 хувьтай байна.

Тэтгэврийн даатгалын сангаас 18560 тэтгэвэр авагчдад 84404401 мянган төгрөгийг олголоо.

Тэтгэмжийн даатгалын сангаас 5814 даатгуулагчдад 2895859 мянган төгрөгийн ХЧТА, жирэмсэн болон амаржсаны, оршуулгын тэтгэмж олгожээ.

ҮОМШӨ-ний даатгалын сангаас 206 даатгуулагчид 963502 мянган төгрөгийн тэтгэвэр, ҮО-ийн тэтгэмж, сувиллын зардалд олгосон байна.

Ажилгүйдлийн даатгалын сангаас 523 даатгуулагчдад 1038017 мянган төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж олгосон.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс нь 10 дугаар сард 2 удаа хуралдаж нийт 172 иргэн даатгуулагчид эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйлчилгээ үзүүлж 35 иргэнд шинээр хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацаа тогтоож 15 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг сунгаж 112 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ хугацааг цуцалсан байна.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс нь нүүдлийн хурлыг Мандал, Сайхан, Баянгол суманд зохион байгуулж нийт 259 иргэн даатгуулагчид эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйлчилгээ үзүүлж 4 иргэнд шинээр хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацаа тогтоож 21 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг сунгаж 234 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ хугацааг цуцалсан байна.

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн талаар: Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, ГХУСАЗ Зөвлөл, Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны ажлын алба, Цагдаагийн газар, “Дэлхийн зөн Монгол” ОУБ-ын Сэлэнгэ орон нутгийн хөтөлбөртэй хамтран Цагдаагийн газрын мөрдөн байцаагч нарт **“Насанд хүрээгүй хүүхэдтэй ажиллах арга зүй”** сургалт зохион байгууллаа. Нийт 46 мөрдөн байцаагч хамрагдсан.

“Нэгдүгээрт хүүхэд” хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах арга хэмжээний төлөвлөгөөт хяналт шалгалтын ажлын нэгдсэн удирдамжийн дагуу 17 сум 6 тосгоны 40 хамтарсан багийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө зөвлөмж өгч ажиллалаа. Хамтарсан багийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтад Түшиг, Цагааннуур, Зүүнбүрэн, Хушаат, Хүдэр, Ерөө, Жавхлант, Баруунбүрэн, Сайхан, Баянгол, Мандал, Сүхбаатар, Алтанбулаг, Шаамар сумын 15 ерөнхий боловсролын сургууль, 16 дотуур байр, 16 цэцэрлэг хамрагдсан. Шалгалтаар нийт давхардсан тоогоор 24 зөрчлийг илрүүлж, шаардлагатай 5 сумын Засаг дарга бөгөөд Хүүхдийн төлөө зөвлөлийн тэргүүн нарт хугацаатай албан шаардлага хүргүүлээд байна.

Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээг 3 зорилтын хүрээнд Зүүнбүрэн, Алтанбулаг, Түшиг, Ерөө суманд газар дээр нь шуурхай үзүүлж, дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж “Гэр бүл төлөвлөлт, гэр бүлийн харилцаа”, “Гэр бүл хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нь”, “Хүмүүжлийн эерэг арга” сэдэвт нөлөөллийн ажлыг зохион байгуулж, нийт 188 иргэдийг хамруулсан.

Хүүхэд хамгааллын үйлчилгээг мэргэжлийн түвшинд үзүүлэх чадавхжуулах, зөвлөн туслах ажлыг шинээр томилогдсон 12 хамтарсан багийн 60 гишүүдэд “Кейс менежментийн зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, гишүүдийн үүрэг, оролцоо, кейс төлөвлөлтийн талаарх мэдлэгийг олгож, ажлын байранд чадавхжуулах, зөвлөн туслах ажлыг зохион байгуулсан.

Эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа нийт 126 сурагчдад “Мэргэжлээ хэрхэн зөв сонгох вэ?”, “Үе тэнгийнхний дарамт шахалт”, “Харилцаа хандлага”, “Анги хамт олонд нь эргэн нэгтгэх” зэрэг сэдвийн хүрээнд сэтгэл зүйн зөвлөгөө өгч тэдэнд

тулгамдаж буй асуудлын талаар ганцаарчилсан зөвлөгөөг 26, бүлгийн зөвлөгөө 100, нийт 126 сурагчдад ярилцлага хийсэн.

Гэр бүлд зөвлөгөө өгөх төвөөр насанд хүрэгч-1, 4 хүүхдэд сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөө үйлчилгээг 1-4 удаагийн давтамжтай үзүүлсэн. Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээний хүрээнд Түшиг, Алтанбулаг, Зүүнбүрэн, Ерөө сумын Ерөнхий боловсролын 126 сурагчдад сэтгэл зүйн ганцаарчилсан болон бүлгийн зөвлөгөө үйлчилгээ үзүүлсэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын албадлагын арга хэмжээ авсан, хорих ял эдэлж байгаа 8 иргэнд зан үйлд нөлөөлөх сэтгэл зүйн сургалтыг хуваарын дагуу зохион байгуулж ажилласан.

“Мэргэшсэн мэргэжил” сургалтын төвтэй хамтран Сүхбаатар сумын ажил хөдөлмөр эрхлээгүй 18-34 насны 30 залууд “Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох” сургалтыг зохион байгуулсан. “Оролцоо төсөл миний амьдралд” арга хэмжээг Зүүнбүрэн, Алтанбулаг, Түшиг, Ерөө суманд зохион байгуулсан.

Зүүнбүрэн, Алтанбулаг, Түшиг, Ерөө сумдуудад Youth Vox болон явуулын үйлчилгээ, “Гэр бүл төлөвлөлт, харилцаа” нөлөөллийн сургалтыг 151 иргэнд, Хөдөлмөр эрхлэлтийн нээлттэй ажлын байрны заруудыг залуучуудад түгээх ажлыг зохион байгуулсан.

Зорилтод гэр бүлд чиглэсэн эрсдэлийн үнэлгээ хийж, үнэлгээ судалгаанд суурилан хамрагдсан иргэдээс 30 өрхийг сонгон ажил олоход хүндрэлтэй иргэн, ялангуяа нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн хөдөлмөрийн насны бөгөөд хөдөлмөрийн чадвартай гишүүнийг хөдөлмөрт бэлтгэж, ажлын байранд холбон зуучлах, эмэгтэйчүүдийг хөдөлмөр эрхлэхэд тулгарч буй бэрхшээлийг арилгаж, тэдэнд болон гэртээ удаан хугацаагаар хүүхдээ харж буй бага насны хүүхэдтэй ээжүүдэд цахим болон шаардлагатай ур чадвар олгох, сургалт, дэмжлэгт хамруулах замаар тэдний орлогыг нэмэгдүүлэхэд чиглэн уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын чиглэлээр төрөөс баримталж буй хууль тогтоомж, дүрэм журам, стандартын хэрэгжилтийг ханган ажиллах зорилгоор Хамтарсан багийн гишүүдийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, чадавхжуулах зорилгоор Зүүнбүрэн, Алтанбулаг, Түшиг, Ерөө сумдын Засаг дарга, хамтарсан баг, нийгмийн бодлогын мэргэжилтэн, эрүүл мэнд, сургууль, цэцэрлэг, цагдаагийн албан хаагч, төрийн бус байгууллагын төлөөллийг хамруулан нийт 60 иргэнд сургалт зохион байгуулсан. Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эрхийг хамгаалах, аюулгүй байдлыг хангахад төр болон хувийн хэвшил, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, мэдээлэх, олон нийт, эцэг эх, асран хамгаалагчийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх зорилгоор гэр бүлийн харилцаа, гэр бүл төлөвлөлт, хүүхэд хүмүүжлийн эерэг арга, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хууль таниулах сургалтыг Зүүнбүрэн, Алтанбулаг, Түшиг, Ерөө суманд зохион байгуулж нийт 151 иргэн хамрагдсан.

Тав. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хүрээнд:

Хөдөө аж ахуй, газар тариалангийн талаар: Байгууллагын www.mofa.gov.mn/selenge, Сэлэнгэ аймаг Хүнс, Хөдөө аж ахуйн газар facebook хуудсаар байгууллагын үйл ажиллагаа болон аймгийн хөдөө аж ахуйн

салбарын цаг үеийн ажлын мэдээ, мэдээллүүдийг тогтмол байршуулж, иргэдэд хүргэн ажиллаж байна.

2022 онд “Хөдөө аж ахуйг дэмжих” зээлийг үр тариа эрхэлдэг 111 аж ахуйн нэгж иргэнд 13,1 тэрбум төгрөг, төмс хүнсний ногоо эрхэлдэг 129 ногоочдод 4,8 тэрбум төгрөгийн 3 хувийн хүүтэй зээл олгож, шинээр 265 ажлын байр бий болгоод байна.

“Хүнсний ногоо” үндэсний хөтөлбөрийн хүрээнд 11 төрлийн 73,8 сая төгрөгийн ногооны үрийг 20 хувийн хөнгөлөлттэй нөхцөлөөр ногоочдод олгосны үр дүнд төмсний тариалалт 164 га, хүнсний ногооны тариалалт 1115 га-гаар тус тус нэмэгдээд байна.

Ургац хураалтын мэдээг мягмар, лхагва гаригуудад аймгийн хэмжээнд нэгтгэн ХХААХҮЯ-нд хүргэж байна. 10 дугаар сарын байдлаар 118.4 мянган га талбайд хураалт хийснээс нэгж талбайгаас 13.4 цн буюу 158.9 мянган тн үр тариа буюу 88.4 хувьтай, үүнээс улаанбуудай 113.8 мянган га талбайд хураалт хийснээс нэгж талбайгаас 13.6 цн буюу 154.5 мянган тн хурааж 89.6 хувьтай, бусад үр тариа 4583 га талбайд хураалт хийснээс нэгж талбайгаас 9.7 цн буюу 4437 тн, тэжээлийн ургамал 4318 га талбайд хураалт хийснээс нэгж талбайгаа 22 цн буюу 9510 тн, тосны ургамал 37.5 мянган га талбайд хураалт хийснээс нэгж талбайгаас 5 цн буюу 17.4 мянган тн хурааж 76.2 хувьтай, төмс 2089 га талбайд хураалт хийснээс нэгж талбайгаас 122.8 цн буюу 25.6 мянган тн 95.1 хувьтай, хүнсний ногоо 3391.3 га талбайд хураалт хийснээс нэгж талбайгаас 126.5 цн буюу 42.8 мянган тн ургац хураан авсан ба 93.5 хувьтай байна. Төмс хүнсний ногооны хураалт 94.3 хувийн явцтай байна.

Газар тариалангийн нэгдсэн бүртгэлийн системд аймгийн хэмжээнд 17 сумын 293917 га газрыг plant.mofa.gov.mn бүртгэхээс 10 дугаар сарын байдлаар 221750 га газрын бүртгэлийг программд оруулж 82 хувьтай байна.

Улаанбуудайн борлуулалт 51465.97 тн байна. Үүнээс: ХААДС-нд 4854.05 тн, гурилын үйлдвэрт 42921.72 тн, тэжээлд 2650.2 тн, спиртэд 1040 тн тус тус борлуулагдсан байна. Өөрийн үрэнд нөөцөлсөн 4752 тн, агуулахад 8866.87 тн, үтрэм дээр 73256.2 тн байна.

Тариалангийн талбай, түүний хашаа, ойн зурвасыг устгах, гэмтээх тохиолдлуудын судалгааг 17 сумаас авч нэгтгэн ХХААХҮЯ-д гаргаж өгсөн ба 72 удаагийн давтамжтай нийт 2935,6 га-д 1 тэрбум төгрөгийн хохирол тогтоогдож ургац 20 хувиар буурсан дүн гарч байна.

Аймгийн Засаг даргын 2022 оны А/430 тоот захирамжийн хүрээнд “Сэлэнгэ-Алтан намар 2022” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж, аймгийн хэмжээнд 17 сумын төмс, хүнсний ногоо тариалдаг 42 иргэн, 4 хоршоо, жимс жимсгэнэ тариалдаг 5 иргэн, модны үржүүлэг суулгац тариалдаг 7 иргэн аж ахуй нэгж үзэсгэлэнгийн арга хэмжээнд оролцлоо.

Нэгдсэн арга хэмжээнд 16 сум, 6 тосгоноос 127 аж ахуйн нэгж, иргэдийн төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, сүү цагаан идээ, зөгийн бал, даршилж савласан ногоо, тос, эмийн ургамал, гар урлал, модны суулгац, ноос ноолууран эдлэл, арьс, ширэн эдлэл, гутал, зэрэг 100 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнтэйгээр оролцож хүнс, төмс, хүнсний ногоо, хөнгөн үйлдвэрлэлээр 87.165.000 төгрөг, модны суулгацаар 3.470.000 төгрөг нийт 90.635.000 төгрөгийн борлуулалт хийгдсэн байна.

“Сэлэнгэ-Алтан намар 2022” нэгдсэн арга хэмжээний шилдгүүдийг шалгаруулж өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа. Үүнд:

1. “ИМПОРТЫГ ОРЛОХ ШИЛДЭГ БҮТЭЭГДЭХҮҮН”-ээр
 - Баянгол сумын “МайндТеч” ХХК - “Ургамлын тос”,
 - Мандал сумын “Баяннуур Сайхан” ХХК - “Кашмер”
2. “ШИНЭЛЭГ БҮТЭЭГДЭХҮҮН”-ээр
 - Сүхбаатар сумын үйлдвэрлэгч И.Үүрийнцолмонгийн “Давсан урлал”,
 - Алтанбулаг сумын ногоочин Д.Нямдуламын “Амтат төмс”
3. “ШИЛДЭГ САВ БАГЛАА БООДОЛТОЙ БҮТЭЭГДЭХҮҮН”-ээр
 - Зүүнбүрэн сумын “Эхэн өтөг” ХХК-ий “Цагаан идээ”,
 - Баянгол сумын үйлдвэрлэгч Д.Хишигмаагийн “Баянгол цай”
4. “ХЭРЭГЛЭГЧДИЙН ТААШААЛД НИЙЦСЭН БҮТЭЭГДЭХҮҮН”-ээр
 - Сүхбаатар сумын “Алтан тариа” ХХК,
 - Мандал сумын “Энхмөнхжин” бейкери
5. “БОРЛУУЛАЛТ САЙТАЙ БҮТЭЭГДЭХҮҮН”-ээр
 - Баруунбүрэн сумын үйлдвэрлэгч Ч.Алтаннارانгийн “Цагаан идээ”,
 - Сайхан сумын “Хөтөл жимсгэнэ” ХХК-ийн “Мах, махан бүтээгдэхүүн”
6. “ШИЛДЭГ ХУВЦАС ҮЙЛДВЭРЛЭГЧ”-ээр
 - Мандал сумын “Чансаатай гутал”,
 - Сүхбаатар сумын “Emmaa’s салон
7. “ШИЛДЭГ БЭЛГИЙН БАГЦ ҮЙЛДВЭРЛЭГЧ”-ээр
 - Шаамар сумын “Органик бал” хоршооны “Бэлгийн багц”, -
 - Цагааннуур сумын үйлдвэрлэгч Д.Наранцэцэг “Цагаан идээний багц”
8. “ШИЛДЭГ НОГООЧИН”-оор
 - Шаамар сумын ногоочин Ц.Даваасамбуу,
 - Хушаат сумын “Элит үр” ХХК
9. “ШИЛДЭГ СУМ”-аар
 - Ц.Дарханбаатар Засаг даргатай Жавхлант сум,
 - н.Серикбол Засаг даргатай Шаамар сум тус тус шалгарсан.

Мал эмнэлгийн үйлчилгээний талаар: Монгол Улсын Засгийн газрын 225-р тогтоолын 1,2,3-р хавсралт, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2022 оны А/28 тоот тушаал “Дархлаажуулалтын төлөвлөгөөг батлах тухай”, аймгийн Засаг даргын 2022 оны “Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах тухай” А/197 дугаар захирамж, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2022 оны “Бруцеллёзын дархлаажуулалтыг зохион байгуулах тухай” А/166 тоот тушаал, Мал эмнэлгийн газрын даргын 2022 оны “Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах” А/19 тоот тушаал, удирдамжийн хүрээнд төлөвлөгөөт арга хэмжээг хэрэгжүүлж гүйцэтгэлийг мал эмнэлгийн нэгдсэн системд тухай бүр оруулан ажиллаж байна. Гүйцэтгэлийн үр дүн:

- Галзуу өвчний дархлаажуулалтад 48000 толгой мал, амьтан хамрагдахаас 47998 толгой мал, амьтан буюу 99,9 хувь,
- Гахайн мялзан өвчний дархлаажуулалтад 12000 толгой гахай хамрагдахаас 11998 толгой гахай буюу 99.9 хувь,

- Бруцеллёз өвчний дархлаажуулалтад 432000 төл мал хамрагдахаас 432000 төл мал буюу 100 хувь,
- Адууны томуугийн дархлаажуулалтад 32000 толгой мал хамрагдахаас 32000 толгой мал буюу 100 хувийн тус тус гүйцэтгэлтэй технологит хугацаанд хамруулж үйлчилгээний хөлс, бусад зардлыг тооцож төсвөөс санхүүжүүлсэн.

Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтай дархлаажуулалтад 309700 толгой үхэр, 1000 толгой гахай буюу нийт 319700 толгой мал, амьтныг хамруулахаас 4151 өрхийн 173699 үхэр, 4515 гахай буюу нийт 178214 толгой мал, амьтныг дархлаажуулан 55.7 хувийн гүйцэтгэлтэй байна.

Аймгийн Засаг даргын 2022 оны “Мал эмнэлгийн нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах тухай” А/197 дугаар захирамжийн хүрээнд шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний дагуу угаалгад 1667200, туулгалтад 1814510 боловсруулалтад 1438470 толгой мал, амьтан буюу нийт 5158180 толгой мал амьтан хамруулан 97 хувийн гүйцэтгэлтэй байна

Сүхбаатар сумын хэмжээнд хүнсний зах дэлгүүрт худалдан борлуулж байгаа мах махан бүтээгдэхүүний 18270 кг үхрийн махны 87 дээж, 3318 кг хонины махны 154 дээж, 240 кг ямааны махны 12 дээж, сүү, сүүн бүтээгдэхүүний 60 л сүү, ааруул, тараг, цөцгийнй 9 дээжид ариун цэврийн магадлан шинжилгээг стандарт арга зүйн дагуу хийж гүйцэтгэсэн.

Хушаат, Ерөө сумдаас болон импортоор орж ирсэн нийт 239 дээжид ийлдэс судлалын шинжилгээ хийж хариуг мал эмнэлгийн газрын дарга, ерөнхий эмчээр баталгаажуулан малчин, мал бүхий иргэнд, хүргүүлж цахим системд бүртгэсэн.

УМЭАЦТЛ-той хийсэн “Хээлтүүлэгч малд бруцеллёзын тандалт-2022” гэрээний дагуу нийт 8554 хээлтүүлэгч малыг бруцеллёзын шинжилгээнд хамруулахаас бух 2209, хуц 3324, ухна 2712 толгойг буюу 96,4 хувийн гүйцэтгэлтэй хамруулж, бух 3, хуц 4, ухна 3 эерэг дүнтэй гарсан.

Преми-тестийг ашиглан антибиотикийн үлдэгдэл тодорхойлох шинжилгээг хүнс болон тэжээлд антибиотикийн үлдэгдлийг илрүүлэх арга MNS 6665:2017 стандартын дагуу 12 сорьц дээж цуглуулан Ampicillin, Penicillin, Chloramphenicol, бүлгийн антибиотик байгааг илрүүлэх шинжилгээг хийж хариуг олгосон байна.

Сүхбаатар, Алтанбулаг, Зүүнбүрэн сумдын малаас шимэгч судлалын лабораторид 62 дээжид гельминтийн өндөг тоолох шинжилгээ хийгдсэн.

Мал эмнэлгийн лабораторийн цахим мэдээллийн нэгдсэн системд холбогдсоны дагуу харилцагч, үйлчүүлэгчдээс ирсэн 160 сорьц дээжийг vetlab.shinjilgee.mn цахим сүлжээнд бүртгэл, мэдээллийг оруулан лабораторийн нэгдсэн удирдлага, арга зүй, мэдээллийн нэгдсэн сан үүсэх, байнгын хэвийн, найдвартай ажиллагааг, шуурхай байдлыг хангаж ажилласан.

Байгаль орчин, Ус, цаг уурын талаар: Ойн ашиглалт, хяналт, шалгалтын чиглэлээр дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын “Ойн дагалт баялгийн нөөцийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах тухай” 2022 оны 10 тоот албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Ерөө, Мандал, Хүдэр, Түшиг, Цагааннуур, Сант зэрэг сумдын Засаг дарга нарт болон сум дундын Ойн ангиудад чиглэл өгч ажилласан.

2. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын “Байгалийн ойгоос зулзаган мод шилжүүлэн суулгахыг тодорхой хугацаагаар хориглох тухай” 2022 оны А/406 тоот тушаалыг цахим хэлбэрээр олон нийтэд сурталчилж ажиллахын зэрэгцээ сумын болон сум дундын Ойн ангид зөвлөмж хүргүүлж ажилласан.

3. Сэлэнгэ аймгийн хэмжээнд мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэд, аж ахуйн нэгжийн тарьж, ургуулан арчилж буй тарьц суулгацын тоон мэдээлэл, 2022 оны намар зах зээлд борлуулах тарьц, суулгацын тоог хэвлэл, мэдээллээр сурталчилж ажилласан.

Усны чиглэлээр: Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар санхүүжүүлж буй ажлууд болон цаашид авах арга хэмжээний товч мэдээлэл

1. Аймгийн хэмжээнд ундарга, урсац нь багасаж ширгэж болзошгүй булаг, шандын эхийг хашиж хамгаалах ажлыг үргэлжлүүлэн хийх

2. Усны хомсдол бүхий газруудад хөв, цөөрөм байгуулах ажлыг жил бүр хийх. Энэхүү ажлыг хийснээр усан орчин бий болж, зэрлэг амьтад болон бэлчээрийн мал аж ахуйн усан хангамжийн хүртээмж сайжирч, уур амьсгалыг зөөлрүүлнэ.

3. Цаашид онцгой болон энгийн хамгаалалтын бүсийн дэглэмийг ИТХ-аар тогтоохоор судалгааны ажил үргэлжилж байна.

4. Аймагт ус ашигласны төлбөрийн орлогыг жил бүр давуулан биелүүлж, 10 дугаар сарын байдлаар 1,089,845,220 төгрөг төвлөрүүлсэн байна.

Уул уурхайн чиглэлээр:

1. Аймгийн Засаг даргын 2022 оны “Хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах тухай” А/279 дугаар захирамж болон түүний хавсралтаар батлагдсан удирдамж, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын баталсан 2022 оны 01/62 дугаартай “Ашигт малтмалыг хууль бусаар олборлох эрсдэлээс урьдчилан сэргийлэх шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Тагнуулын ерөнхий газрын Сэлэнгэ аймаг дахь газрын хамтарсан хяналт шалгалтыг 2022 оны 09 дүгээр сараас эхлэн хийж гүйцэтгэж байна. Хяналт, шалгалтад Ерөө, Баянгол, Мандал, Орхонтуул сумдын нутаг дэвсгэрт ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж 20 гаруй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагууд хамрагдсан.

Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлуудыг арилгуулах, хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох арга хэмжээг Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Газрын тухай хууль зэрэг холбогдох хуулийн дагуу авч хэрэгжүүлэн ажиллаж байна.

2. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Сэлэнгэ аймгийн Засаг дарга, “Оюу толгой” ХХК-иудын хамтран ажиллах гэрээний дагуу Ерөө сумын Ялбагийн гол нэртэй газарт уул уурхайн улмаас эвдэрч, олон жил эзэнгүй орхигдсон 330.4 га талбайд хийж гүйцэтгэхээс “Бугант нандин” ХХК, “Үзэгт дэлгэр” ХХК 100 га талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэж байна. Тухайн нөхөн сэргээлт хийх газрын хил заагийг “Оюу толгой” ХХК, БОАЖЯ, аймгийн БОАЖГ-ын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдөр ажиллаж хүлээлгэн өгөөд байна.

3. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5 дугаар хэсгийн 5.1.8-д “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас

эвдэрч, олон жил орхигдсон 8000 га талбайг нөхөн сэргээнэ” гэсэн зорилт тусгагдсан. Тус зорилтыг үндэслэн Монгол Улсын Шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд нарын хамтарсан 2020 оны “Нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах тухай” 167, А/698, А/336, А/242 тоот тушаалаар батлагдсан “Нөхөн сэргээлт-2024” нэгдсэн арга хэмжээ хэрэгжиж эхлээд 2 дахь жилдээ үргэлжилж байна.

Зорилт, арга хэмжээний хүрээнд ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагуудын жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд тодорхой хэмжээ бүхий эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийг хийлгүүлэх талаар тусган хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Ус судлал: Манай орны хамгийн том мөрөн Сэлэнгэ мөрний усны түвшин Зүүнбүрэн сум орчмоор усны түвшин 228 см ОЖД-аас 10 см-ээр их, Сүхбаатар сум орчим усны түвшин 339 см ОЖД-аас 99 см-ээр их, Сэлэнгэ мөрний хамгийн том цутгал болох Орхон гол Орхон сум орчим усны түвшин 175 см ОЖД-аас 27 см-ээр их, Сүхбаатар сумаар усны түвшин 196 см ОЖД-аас 31 см-ээр их, Хонгын гол Шарлан голын бэлчрээс Ерөө хэмээн нэрлэгдэнэ. Ерөө гол Ерөө сум орчмоор усны түвшин 282 см ОЖД-аас 3 см-ээр их, Дулаанхан тосгон орчмоор усны түвшин 236 см ОЖД-аас 6 см-ээр их, Хэнтийн салбар уулсаас эх авах Мандал гол, Баян, Сөгнөгөр голтой нийлж, Хараа гол хэмээн нэрлэгдэнэ. Хараа гол Баянгол сум орчмоор усны түвшин 157 см ОЖД-аас 3 см-ээр бага, Бага Хэнтий нурууны Хүдэртийн Хэцийн зүүн хойт салбар уулс, Хаданцаа уулын баруун хажуугаас усжих горхиудын бэлчирээс эхлэн Хүдэр хэмээн нэрлэгдэнэ. Хүдэр гол Хүдэр сум орчмоор усны түвшин 210 см ОЖД-аас 3 см-ээр их, Бүрхэт нурууны салбар Онгон сарьдагийн баруун хойт хажуугаас эх авах Азаргын гол ба Балинтай нурууны зүүн өмнөд хажуу, Хантай нурууны араас усжих Могойт голын бэлчрээс Зэлтэр хэмээн нэрлэгдэнэ. Зэлтэр гол Зэлтэр сум орчмоор усны түвшин 261 см ОЖД-аас 13 см-ээр их байна.

Агаарын чанар: Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын агаарын чанарын харуулын 10 дугаар сарын ажиглалтын дүнгээс үзэхэд агаар дахь хүхэрлэг хийн дундаж агууламж 0.002 мг/м^3 , хамгийн их нь 0.005 мг/м^3 , азотын давхар ислийн дундаж агууламж 0.021 мг/м^3 , хамгийн их нь 0.049 мг/м^3 , нийт тоосны дундаж агууламж 0.063 мг/м^3 , хамгийн их нь 0.040 мг/м^3 байна.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын талаар: Сумдын 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөгөөр батлагдсан газар эзэмших эрхийн дуудлага худалдааг Мандал, Жавхлант, Орхон сумдад зохион байгуулснаас Мандал суманд 47, Жавхлант суманд 8, Орхон суманд 11 дуудлага худалдаа амжилтай зохион байгуулагдсан. Тухайн сард нийт 67 нэгж талбарын дуудлага худалдааг газрын цахим биржид байршуулж зууны мэдээ сонинд зар өгч дуудлага худалдаанд оролцож буй иргэнд утсаар зөвлөгөө өгч ажилласан.

Газрын үнэлгээний системд 17 сумын 12620 нэгж талбарт зам, шугам сүлжээ, хот, тосгон, бусад суурин, усан сан бүхий газрын хүчин зүйлсийн утгыг үнэлгээний системд тооцоолон эдийн засгийн үнэлгээг хийсэн.

Тайлант хугацаанд дараах ажлуудын зураг төсвийг хяналаа. Үүнд:

1. Алтанбулаг сум, Алтанбулаг чөлөөт бүс, “Монгол алтай индастри чөлөөт бүс” ХХК-ий худалдаа үйлчилгээ, агуулахын барилга.

2. Алтанбулаг сум, Алтанбулаг чөлөөт бүс, “Жагро тех чөлөөт бүс” ХХК-ий дэлгүүр, агуулахын барилга.
3. Хушаат сумын Засаг даргын Тамгын газрын барилга.
4. Алтанбулаг сумын Эрүүл мэндийн төвийн ажилчдын байр. /Загвар зураг/
5. Мандал сумын 2-р баг, “Мөнх гал Түшиг” ХХК-ий үйлчилгээтэй орон сууцны барилга. /Загвар зураг/
6. Сайхан сумын зам засвар, тэмдэг тэмдэглэгээ, замын гэрэлтүүлгийн ажил.
7. Хүдэр сумын “Баяр наадмын талбайн зураг”.
8. Баянгол сумын 1-р баг, ахуйн бохир усны биологийн бүрэн “Цэвэрлэх байгууламж”-ийн гадна цахилгаан, цэвэр, бохир, дулааны шугамын трассын зураг зөвшилцсөн.

Архитектор төлөвлөлтийн даалгаврыг Хушаат сумын ЗДТГ-ын шинэ байр, Алтанбулаг чөлөөт бүс, “Монгол алтай индастри чөлөөт бүс” ХХК-ий худалдаа, үйлчилгээ, агуулахын барилга, Ерөө сумын “Хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөө”-ний зургийн даалгаврыг ГЗБГЗЗГ-т хянуулж баталгаажуулав.

Хот байгуулалтын кадастрын Urban manager цахим системд тохижилт, ногоон байгууламжийг зурж, бүртгэх ажлын хүрээнд 10 дугаар сарын байдлаар Ерөө, Хушаат, Хүдэр, Зүүнбүрэн сумд болон Хэрх, Түнхэл, Дулаанхан, Номгон, Бугант тосгодын ногоон байгууламжуудыг тус тус зурж, системд оруулах хүсэлтээ өгөөд байна. Ингэснээр Сэлэнгэ аймгийн хүрээнд бүх сум, тосгодын ногоон байгууламжийг 100 хувь бүрэн зурж дуусгалаа. Системд оруулсан ногоон байгууламжийг бүртгэх ажлын явц 70 хувьтай.

Хот байгуулалтын кадастрын Urban manager цахим системд автозамын байгууламжийг зурж, бүртгэх ажлын явц 80 хувьтай явж байна. Олон улсын чанартай болон, сум хоорондын авто замыг бүртгэж дууссан. Зарим сумдын дотор авто замыг бүртгэх ажил явагдаж байна.

Барилга угсралтын болон засварын ажилд ажил эхлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгосон байдал:

1. Баруунбүрэн суманд өвөл зуны хүлэмж барих ажилд 2022-09-23-ны өдрийн БУ-120/2022 тоот ажил эхлүүлэх зөвшөөрөл олгов.
2. Сумын төвийн нийтийн эзэмшлийн зам засварын ажилд 2022-09-23-ны өдрийн АЗ-121/2022 тоот ажил эхлүүлэх зөвшөөрөл олгов.
3. Ерөө суманд Ерөө үржүүлгийн төв байгуулах ажилд 2022-09-30-ны өдрийн БУ-122/2022 тоот ажил эхлүүлэх зөвшөөрөл олгов.
4. Хорооллын дундах зам засварын ажилд 2022-09-30-ны өдрийн АЗ-123/2022 тоот ажил эхлүүлэх зөвшөөрөл олгов.
5. Жавхлант суманд хатуу хучилттай замын ажилд 2022-09-30-ны өдрийн АЗ-124/2022 тоот ажил эхлүүлэх зөвшөөрөл олгов.
6. Шинэ суурьшлын бүсэд худаг гаргах ажилд 2022-09-30-ны өдрийн БУ-125/2022 тоот ажил эхлүүлэх зөвшөөрөл олгов.
7. Замын нөхөөс хийх ажилд 2022-09-30-ны өдрийн АЗ-126/2022 тоот ажил эхлүүлэх зөвшөөрөл олгов.
8. 3-р багт тоглоомын талбай байгуулах ажилд 2022-09-30-ны өдрийн ГТ-127/2022 тоот ажил эхлүүлэх зөвшөөрөл олгов.
9. Цэцэрлэгийн барилгын их засварын ажилд 2022-10-03-ны өдрийн БЗ-128/2022 тоот ажил эхлүүлэх зөвшөөрөл олгов.

10. “Шанд-Ургац” ХХК-ий Хөдөө аж ахуйн гадна цахилгаан хангамжийн ажилд 2022-10-03-ны өдрийн ЦХ-129/2022 тоот ажил эхлүүлэх зөвшөөрөл олгов.
11. Зам даваа засах ажилд 2022-10-03-ны өдрийн АЗ-130/2022 тоот ажил эхлүүлэх зөвшөөрөл олгов.
12. Баянцогт 2-р багийн 2 орцтой орон сууцны барилгын дээвэр засварын ажилд 2022-10-03-ны өдрийн БЗ-131/2022 тоот ажил эхлүүлэх зөвшөөрөл олгов.
13. Төрийн албан хаагчийн 4 айлын орон сууц барих ажилд 2022-10-14-ний өдрийн БУ-132/2022 тоот ажил эхлүүлэх зөвшөөрөл олгов.
14. Аймгийн Засаг даргын Тамгын газрын гадна фасад, дотор их засварын ажилд 2022-10-20-ны өдрийн БЗ-133/2022 тоот ажил эхлүүлэх зөвшөөрөл олгов.
15. “Сити нойл”-ын ажилд 2022-10-20-ны өдрийн БУ-134/2022 тоот ажил эхлүүлэх зөвшөөрөл олгов.
16. Хүдэр сумын төвийн гэрэлтүүлгийн ажилд 2022-10-20-ны өдрийн ЦХ-135/2022 тоот ажил эхлүүлэх зөвшөөрөл олгов.
17. Засаг даргын Тамгын газрын урсгал засварын ажилд 2022-10-20-ны өдрийн БЗ-136/2022 тоот ажил эхлүүлэх зөвшөөрөл олгов.
18. Хушаат сумын Ишгэнт, дуулга хороололд цахилгаан шугам татах ажилд 2022-10-20-ны өдрийн ЦХ-137/2022 тоот ажил эхлүүлэх зөвшөөрөл олгов.
19. Хушаат сумын Ишгэнт хорооллын гудамжны гэрэлтүүлэг засварын ажилд 2022-10-20-ны өдрийн ЦХ-138/2022 тоот ажил эхлүүлэх зөвшөөрөл олгов.
20. Шинэ суурьшлын бүсэд гүний худаг гаргах, худгийн барилга барих, худгийн автоматжуулалт хийх ажилд 2022-10-20-ны өдрийн ГХ-139/2022 тоот ажил эхлүүлэх зөвшөөрөл олгов.
21. Зам засвар, тэмдэг тэмдэглэгээ, замын гэрэлтүүлгийн ажилд 2022-10-24-ний өдрийн ЦХ-140/2022 тоот ажил эхлүүлэх зөвшөөрөл олгов.
22. Сант сумын 2-р багт бог мал угаалгын ванн барих ажилд 2022-10-24-ний өдрийн БУ-141/2022 тоот ажил эхлүүлэх зөвшөөрөл олгов.
23. Түшиг сумын зам засвар, тэмдэг тэмдэглэгээ, замын гэрэлтүүлгийн ажилд 2022-10-24-ний өдрийн ЦХ-142/2022 тоот ажил эхлүүлэх зөвшөөрөл олгов.
24. Ерөө сумын 200 хүүхдийн цэцэрлэгийн ажлыг үргэлжлүүлэх зөвшөөрлийг 2022-09-29-ний өдөр 2022.09.29-2022.11.20-ны өдрийг хүртэл сунгав.
25. Алтанбулаг хилийн боомтын барилга, байгууламжийн өргөтгөл, шинэчлэлийн барилга угсралтын ажлыг үргэлжлүүлэх зөвшөөрлийг 2022-09-29-ний өдөр /2022.09.28-2022.12.30-ны өдрийг хүртэл/ сунгав.
26. Зүүнбүрэн тооцооны төвийн барилга угсралтын ажлыг үргэлжлүүлэх зөвшөөрлийг 2022-10-10-ны өдөр /2022.09.12-2022.12.09-ний өдрийг хүртэл/ сунгав.
27. Автомашин болон ахуйн баллон хийгээр цэнэглэх станц барих ажлыг үргэлжлүүлэх зөвшөөрлийг 2022-10-20-ны өдөр /2022.09.15-2022.11.01-ний өдрийг хүртэл/ сунгав.

Улсын комисс ажилласан байдал:

1. “Алтан намрын шим” худалдаа үйлчилгээний газрын зогсоол байгуулах ажлыг ашиглалтад оруулахаар 2022-09-29-ний өдөр
2. Иргэн Б.Энхцэцэгийн граж авто машины засварын зориулалттай барилгын ажлыг ашиглалтад оруулахаар 2022-10-14-ний

3. Иргэн Д.Оч-Эрдэнийн граж, агуулахын зориулалттай барилгын ажлыг ашиглалтад оруулахаар 2022-10-14-ний өдөр
4. Зам талбайн тохижилт, ногоон байгууламж нэмэгдүүлэх ажлыг ашиглалтад оруулахаар 2022-10-19-ний өдөр
5. Овоот, Дөмбөн хорооллын автозамыг хатуу хучилттай болгох ажлыг ашиглалтад оруулахаар 2022-10-19-ний өдөр
6. Орхон сумын дулааны шугам тавих” ажлыг ашиглалтад оруулахаар 2022-10-19-ний өдөр
7. Орхон сумын дулааны шугамын өргөтгөлийг ашиглалтад оруулахаар 2022-10-19-ний өдөр
8. Ерөө сумын төвийн нийтийн эзэмшлийн зам засварын ажлыг ашиглалтад оруулахаар 2022-10-20-ны өдөр
9. Жавхлант сумын зам засвар, тэмдэг тэмдэглэгээний ажлыг ашиглалтад оруулахаар 2022 оны 10–р сарын 20-ны өдөр тус тус улсын комисс ажиллаж үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулав.

Зургаа. Сум орон нутгийн ажил үйлчилгээний талаар:

Алтанбулаг сум:

Сумын Засаг даргын 2022 оны “Бүх нийтээр мод тарих өдрийг зохион байгуулах тухай” А/142 дүгээр захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллаж сумын хэмжээнд төр, төсвийн байгууллагууд нийт 523 ширхэг мод буцыг тарьсан.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Хяраан голын гүүр шинээр барих ажлыг 592,900,000 төгрөгөөр “Хавай интернешнел групп” ХХК гүйцэтгэж, 90 хувийн гүйцэтгэлтэй ажиллаж байна.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр

- Ерөнхий боловсролын сургуулийн цахим ангийг 13.900,000 төгрөгөөр “Маймеч” ХХК шууд худалдан авалтаар ажлыг 100 хувь хийж гүйцэтгэсэн.
- 2 дугаар цэцэрлэгийн сантехникийн засварын ажлыг 106.100,000 төгрөгөөр “Даян өгөөж” ХХК тендерт шалгарч ажлыг 100 хувь гүйцэтгэсэн.
- Зам засвар, тэмдэг тэмдэглэгээ, замын гэрэлтүүлгийг 50,000,000 төгрөгөөр “Есөн эрдэнэ” ХХК 100 хувь гүйцэтгэсэн.
- Соёлын төвд тоног төхөөрөмж худалдан авах ажлыг 20,000,000 төгрөгөөр “Акустика музика” ХХК 100 хувь гүйцэтгэсэн.
- Ерөнхий боловсролын сургуулийн дээвэр засварын ажлыг 56,500,000 төгрөгөөр “Индио менежмент” ХХК 100 хувь гүйцэтгэсэн.

Үр тарианы аж ахуйн нэгжид ургац хураалтын ажил 93 хувьтай явагдаж байна. Улаан буудай 4910 га-аас 2636 тн, арвай 331 га-аас 267 тн, Овьёос 1260 га-аас 1100 тн, Рапс 2945 га-аас 321 тн тус тус хураагаад байна.

Баруунбүрэн сум:

Сумын хэмжээнд төмс, хүнсний ногооны ургац хураалт дуусаж, үр тарианы ургац хураалт 90 хувьтай явагдаж байна. Нийт 480 тонн төмс, 289 тонн хүнсний ногоо хураан аваад байна.

“Сэлэнгэ Алтан намар-2022” нэгдсэн арга хэмжээнд тус сумаас 20 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнээр 4 иргэн хамрагдаж 3500000 /Гурван сая таван зуун мянган төгрөг/-ийн борлуулалт хийж, сумын цагаан идээ үйлдвэрлэгч малчин Ч.Алтаннаран “Борлуулалт сайтай бүтээгдэхүүн” номинациар шалгарлаа.

Сумын хэмжээнд хуш модны самрыг ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалттай бэлтгэж байгаатай холбогдуулан тогтмол хяналт шалгалтын ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Хуш модны самрыг үйлдвэрлэлийн зориулалттай бэлтгэх 12 аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан тээвэрлэлтэд хяналт тавин ажиллаж байна.

2022-2023 оны хичээлийн жил эхэлсэнтэй холбогдуулан Эрүүл мэндийн төвөөс Ерөнхий боловсролын сургуулийн 480 хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт зохион байгууллаа.

Сайхан сумын Сум дундын цагдаагийн хэлтэс, сийн Хүүхэд олон нийтийн мэргэжилтэн н.Лхагваа, Сайхан сум дахь сум дундын Прокурорын газрын прокурор н.Бадам нар сумын “Хамтарсан багийн үйл ажиллагааны чиглэл”, “Зам тээвэр”, “Зөрчлийн тухай хууль”-уудаар сургалт зохион байгуулж нийт 56 суралцагч хамрагдлаа.

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын “Намрын спартикад” спортын уралдаан тэмцээнийг зохион байгуулахад 20 бүлгийн нийт 116 сурагч оролцлоо.

Төгсөх 12 дугаар ангийн суралцагчид “Жаргалтай бага насны дурсамж” тайлан тоглолтыг зохион байгуулж, ерөнхий боловсролын сургуулийн суралцагчид болон эцэг эхчүүдэд толилууллаа.

Аймгийн Соёл урлагийн салбарын Соёл урлагийн ажилтны баярын арга хэмжээнд “Нүүдэлчин Монгол-2022” наадамд амжилттай оролцсон ардын авьяастан Ү.Цогбадрах Монгол Улсын Соёлын тэргүүний ажилтан цол тэмдгээр шагнагдлаа.

Баянгол сум:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр зарлах тухай” 63 дугаар зарлиг, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2022 оны “Бүх нийтээр мод тарих сарын ажлыг зохион байгуулах тухай” 12 тоот албан даалгаврын хүрээнд модны тарьц суулгац худалдааны үзэсгэлэн зохион байгуулж 150 ширхэг мод бут худалдан борлуулсан.

Тус ажлын хүрээнд сумын Засаг даргын Тамгын газрын 22, Ерөнхий боловсролын сургуулийн 10 багш, 11 дүгээр ангийн 70 суралцагч, Цагдаагийн хэсгийн 5, Гал түймэр унтраах аврах 40-р ангийн 8, Хүмүүнлэг 5-р ангийн 5 ажилтан, албан хаагч зэрэг нийт 5 албан байгууллагын 110 албан хаагч хамтран “Ахмад, залуучуудын өргөө”-ний хашаанд 200 ширхэг нарс суулгалаа.

Мөн сумын хэмжээнд 19 өрх 145 ширхэг, 10 албан байгууллага 8981 ширхэг мод тарьсан байна.

Аймгийн Засаг даргын 2022 оны А/230 тоот захирамжийн дагуу 2022 оны 2-р ээлжийн хугацаат цэргийн албаны татлагад хамрагдах 72 залуусын судалгааг гаргаж, 148 иргэнд “Цэргийн жинхэнэ албанд зарлан дуудах мэдэгдэл”-ийг биечлэн хүргэж, 23 иргэнд утсаар мэдэгдэж, цэрэг татлагын эрүүл мэндийн үзлэгт хамрагдуулснаар 5 иргэн тэнцэж, хугацаат цэргийн албанд мордлоо.

Монголын ахмадын баярын өдрийн хүрээнд сумын Ахмадын баярын арга хэмжээний хүндэтгэлийн хурал, баярын хүлээн авалт, “Бидний аялгуу” урлагийн тоглолтыг зохион байгуулж 400 гаруй ахмад настан оролцлоо.

Баянгол сумын эртний сүм, хийдийн туурийг “Монгол Улсын сүм хийд” цуврал номд бичиж үлдээх зорилгоор Хараа багийн Түнхий хийдийн туурь, Баян

багийн Баянгол, Тариат, Их, Бага мухар хэмээх газруудаар сүм хийдийн туурийг судлах ажлыг цуврал ном бүтээгч Н.Ганбаттай хамтран зохион байгууллаа.

Дэлхийн багш нарын 28, Монголын багш нарын 56 дахь баярын өдрийг сумын боловсролын байгууллагууд тэмдэглэн өнгөрүүллээ. Тус арга хэмжээнд цэцэрлэгийн үе үеийн ахмад багш ажилчид оролцож, Боловсрол шинжлэх ухааны яам, Боловсрол шинжлэх ухааны газар, аймаг, сумын шагналуудаар нийт 73 багш ажилчдыг шагналаа.

Сумын Засаг даргын үүрэг чиглэлийн дагуу өвөлжилтийн бэлтгэл хангах, цаг үеийн ажлыг эрчимжүүлэх арга хэмжээг зохион байгуулж Хараа 1-р баг 1984 га талбайд 129 иргэн, Баян 2-р баг 2833,5 га талбайд багийн 173 иргэнд, Шарын гол сумын 18 иргэнд, Гонир 3-р баг 1040 га талбайд 96 иргэнд байгалийн ургамлыг хадлангийн зориулалтаар ашиглах эрхийн бичгийг тус тус олгосон байна.

“Сэлэнгэ алтан намар-2022” нэгдсэн арга хэмжээнд “Майнд теч” ХХК ургамлын тосоор, Хараагийн баян үрс хоршоо, Ч.Оюун нар 22 нэр төрлийн даршилсан ногоогоор, Д.Хишигмаа 14 нэр төрлийн эмчилгээний ургамлын цайгаар оролцож “Майнд теч” ХХК “Импортыг орлох шилдэг бүтээгдэхүүн”, Д.Хишигмаа “Шилдэг бүтээгдэхүүн”-ээр тус тус шалгарч амжилттай оролцлоо.

Ерөө сум:

Аймгийн Засаг даргын 2022 оны А/390 дугаар захирамжийг үндэслэн Ерөө сумын Засаг даргын 2022 оны А/206 дугаар захирамжаар 2022 оны 2 дугаар ээлжийн хугацаат цэрэг татлагын ажлыг зохион байгуулж, 1996-2004 оны цэргийн насны нийт 448 залууд зарлан мэдэгдэх хуудсыг хүргэн эрүүл мэндийн үзлэгт нийт 55 залуу хамрагдсанаас 21 залуу тэнцсэн байна.

Сумын Засаг даргын 2022 оны А/185 дугаартай захирамжаар Тамхи худалдаалах тусгай зөвшөөрөл олгох шийдвэрийг шинэчлэн баталж, орон нутагт үйл ажиллагаа явуулж буй худалдаа үйлчилгээний газрын хүсэлтийн дагуу шаардлага хангасан 2 хүнсний дэлгүүрт Тамхи худалдаалах тусгай зөвшөөрөл олголоо.

“Сэлэнгэ Алтан намар-2022” нэгдсэн арга хэмжээнд сумын 12 иргэн, аж ахуй нэгж оролцон, нийт 34 төрлийн бүтээгдэхүүнээр 3.000,000 төгрөгийн борлуулалт хийсэн. Уг арга хэмжээний үеэр суманд 3.000,000 төгрөгийн үнэ бүхий 4*8 харьцаатай хүлэмж, Бугант цахир хоршооны ахлагч Д.Эрдэнэчимэг аймгийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр, “Бугант минж” ХХК “Импортыг орлох бүтээгдэхүүн”-тэй аж ахуй нэгжээр шалгарлаа.

Өвөл цагийн соёл хүмүүжлийн ажлын хүрээнд Ерөө сумын сумын Засаг даргын Тамгын газраас Төрийн бус байгууллага, аж ахуй нэгж, иргэдийн дунд “**YERUU CUP-2022**” таван төрөлт спортын арга хэмжээ зохион байгуулж ажиллалаа.

Жавхлант сум:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжиж буй “ТЭРБУМ МОД” үндэсний хөдөлгөөн болон аймгийн Засаг даргын 2022 оны “Бүх нийтээр мод тарих өдрийг зохион байгуулах тухай” А/380 дугаар захирамжийн дагуу STREAM төсөлтэй хамтран мод тарих ажлыг Бумбат 1 дүгээр багийн Шарын голын тосгоны ард хамгаалалтын ойн зурваст газарт зохион байгуулж, арга хэмжээнд төр төсвийн 4 байгууллага, Ахмадын хороо нийт 52 иргэдийн оролцоотой 850 ширхэг улиас, хайлаас, чацаргана, бургас тарьж, усалгааг хийлээ.

Мөн STREAM төслийн хүрээнд сумын Засаг даргын Тамгын газартай хамтран сумын төвийн цэцэрлэгт хүрээлэнгийн дэргэд навчит модны эх ургамлын талбай болгох зорилгоор 50х30 метр хэмжээ бүхий мод үржүүлгийн газрын хашааг шинээр барьж, төлөвлөгөөний дагуу хөрс боловсруулалтын ажлыг хийж гүйцэтгэлээ.

Цаашид хайлаас, бүйлс, агч, шар хуайс, улиас зэрэг навчит ургамлыг үрээр болон мөчрөөр ургуулж сумын ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх, иргэдэд мод тарих сургалтыг зохион байгуулах, тариалангийн болон хамгаалалтын ойн зурваст ашиглах тарьц, суулгацыг нийлүүлэх зорилготойгоор байгуулж байна.

Аймгийн Засаг дарга Н.Лхагвадорж, аймгийн Засаг даргын орлогч Ц.Рэгзэдмаа нар 2022 онд аймгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажил болон өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд төр төсвийн байгууллагуудын халаалтын үйл ажиллагаатай танилцлаа.

Аймгийн Засаг даргын захирамжаар зохион байгуулагдсан “Сэлэнгэ Алтан намар-2022” нэгдсэн арга хэмжээнд “Зохион байгуулалттай шилдэг сум”-аар шалгарлаа.

Аймгийн Засаг даргын А/390 захирамжийн дагуу Жавхлант суманд Жавхлант, Хүдэр, Хушаат, Ерөө сумууд болон Бугант тосгоны цэргийн насны залуучууд цэрэг татлагын үзлэгт хамрагдлаа.

Сумын Ахмадын баярыг тэмдэглэж ахмад буурлуудаа шагнаж урамшууллаа.

- Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Хүндэт өргөмжлөл”-өөр С.Бүрнээ, С.Жавзмаа
- Сумын Засаг даргын “Жуух бичиг”-ээр Т.Даваа, Ж.Цэцгээ,
- Сумын Засаг даргын “Талархал”-аар Б.Батдаваа нар тус тус шагнагдлаа.

Мөн тус өдрийн угтан сумын ахмадуудын дунд Даам, теннис, дардас, софт волейбол, хөгжөөнт буухиа тэмцээнүүдийг зохион байгуулж 105 ахмад оролцлоо.

Сумын Засаг даргын баталсан удирдамжийн дагуу бүх нийтийн хог цэвэрлэгээг зохион байгуулж, төр, төсвийн байгууллагын 55 албан хаагчид, 10 иргэн нийт 65 орчим га талбайн 8 тн хог хаягдлыг цэвэрлэсэн.

Зүүнбүрэн сум:

Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигаар зарлагдсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Ногоон Зүүнбүрэн аян”- ны хүрээнд 2022 оны намрын мод тарих арга хэмжээний хүрээнд 5 аж ахуй нэгж байгууллага, 14 айл, өрх нийтийн эдэлбэр газар болон байгууллагын гадна тохижилтын ажлыг өөрсдийн дотоод нөөцөд тулгуурлан хийж монос, агч, хус, үхэр нүд, улиас зэрэг 5 төрлийн 136 ширхэг модыг тарьж 02 сот газарт ногоон байгууламж шинээр байгуулан 526 ширхэг модонд арчилгаа хийлээ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 200 тн-ын багтаамжтай бүрэн автомат ногоо хадгалах зоорийг барьж хүлэмжийн аж ахуйн ашиглалтад орууллаа.

Аймгийн Засаг даргын захирамжаар зохион байгуулагдсан “Сэлэнгэ Алтан намар-2022” үзэсгэлэн худалдаанд тус сумаас 8 өрхийн үйлдвэрлэгч оролцож, 1.500,000 төгрөгийн борлуулалтыг хийж “Эхэн-Өтөг” ХХК-ий үйлдвэрлэсэн сүү, сүүн бүтээгдэхүүн нь “Шилдэг бүтээгдэхүүн” номинацид шалгарлаа.

Олон Улсын “Ахмадын баяр”-ын өдрийн хүрээнд сумын хэмжээнд 120 гаруй ахмад настныг хүлээн авч хүндэтгэл үзүүллээ. Уг арга хэмжээний үеэр төрийн одон медалиар 3 иргэн шагнагдаж, нийт ахмадууддаа гарын бэлэг гардуулан, танин мэдэхүйн асуулт, хариултын хөгжөөнт “АХА” тэмцээн, сугалаа зэргийг зохион байгууллаа.

Намрын ажлын үед алслагдсан багийн малчин өрхүүд болон үр тарианы аж ахуй нэгжүүдэд соёл, урлагийн арга хэмжээ хүргэх ажлыг 5 удаа зохион байгуулж нийт 100 гаруй иргэн хамрагдсан байна.

Сумын хэмжээнд “Үе тэнгийнхний дээрэлхэлт, ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх” сарын аяныг зарлан аяны хүрээнд хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ сэдэвт сургалтад төрийн албанд шинээр орсон албан хаагчдыг хамруулан чадавхжуулах сургалтыг зохион байгууллаа.

Сумын Засаг даргын Тамгын газар нь “Энхбүрэн-сүрэг”, “Оюут-сүрэг” мал эмнэлгийн нэгжүүдтэй хамтран “Хайрын бэлэг” төслийг 3 дахь жилдээ зохион байгуулж, 10 өрх бүрт тус бүр 3 толгой хонь бэлэглэлээ.

Сумын Засаг даргын 2022 оны А/ 187 тоот захирамжаар шүлхий өвчний давтан тун тарилгын ажлыг сумын хэмжээнд зохион байгуулан 7315 толгой мал буюу 44,6 хувийг хамрууллаа.

2022 оны намрын ургац хураалтаар сумын хэмжээнд 14610,7 тн Улаанбуудай, 896,1 тн бусад үр тариа, тэжээлийн ургамал 1403 тн, Рапс 1617 тн, төмс 180 тн, хүнсний ногоо 1460 тн хураасан байна.

Аймгийн Засаг даргын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах 02 тоот албан даалгаврын хүрээнд Халаалтын төв 3 зууханд засвар үйлчилгээг хийж гэмтэл гарсан 50 метр шугамыг шинэчилж, шинээр 2 байгууллагад дулааны шугамын холболтыг хийж хэрэглэгчийн тоог нэмэгдүүллээ.

Бүх нийтийн хог цэвэрлэгээг зохион байгуулан нийтийн эдэлбэр газар болон байгууллагын гадна орчин болох 42 нэгж талбарыг аж ахуй нэгж байгууллагуудад хариуцуулан 20 тн хог хаягдлыг цэвэрлэж устгалаа.

Мандал сум:

Мэдээллийн ил тод байдлыг ханган иргэдийг мэдээ, мэдээллээр хангах зорилгоор хөдөө аж ахуйн салбар, статистик, ойн анги, эд хөрөнгийн улсын бүртгэл, иргэний бүртгэл, багийн дарга цаг үеийн мэдээлэлтэй холбоотой 10 видео бичлэг, зарын чанартай 18, үйл явдлын 19, цаг үеийн 12, бүтээн байгуулалтын 6, Мандал сум 2023 санал асуулга 1, нийт 50 фото мэдээ, мэдээлэл бэлтгэн боловсруулж байгууллагын цахим хаягт байршуулан олон нийтэд хүргэн ажиллалаа.

Албан хаагчдыг чадавхжуулах, мэдлэг чадварыг нэмэгдүүлэх зорилгоор “Мэргэжлийн тасралтгүй хөгжил”, “Төр хувийн хэвшил ба түншлэл” сэдэвт мэргэшүүлэх болон дунд хугацааны сургалтад 1 албан хаагчийг тус тус хамрууллаа.

Герман улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн STREAM төсөлтэй хамтран Мандал суманд зөгийн аж ахуй эрхэлдэг 6 иргэн, 5 нөхөрлөл, 1 аж ахуй нэгж байгууллагуудын төлөөлөл нийт 12 иргэнийг 3 өдрийн сургалтад хамрууллаа.

Аймгийн Засаг даргын 2022 оны “Хугацаат цэргийн албаны ээлжит татлага зохион байгуулах тухай” А/390, сумын Засаг даргын 2022 оны А/346 дугаар

захирамжийн хэрэгжилтийг ханган 2022 оны хугацаат цэргийн албаны ээлжит татлагыг аймгийн цэргийн штабтай хамтран зохион байгуулж ажиллалаа.

2023 онд Архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтын улсын үзлэг болохтой холбогдуулан аймгийн Засаг даргын Хууль зүйн хэлтсийн Төрийн архивын тасгийн бүрэлдэхүүн тус сумын төр, төсвийн 25 байгууллагын дарга, архив, бичиг хэргийн нийт 41 албан хаагчдад хууль эрх зүйн болон арга зүйн сургалтыг зохион байгууллаа.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Алсын Хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын зорилго, зорилт үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар “Үндэсний бичгийн эх бидний соёл, Үндэсний нэгдмэл үнэт зүйл, Хүний хөгжил, Ногоон хөгжил, Амар тайван аюулгүй нийгэм, Амьдралын чанар ба дундаж давхарга, Эдийн засаг, Бүсчилсэн хөгжил, Улаанбаатар ба дагуул хот, Сайн засаглал зэрэг шинэ сэргэлтийн бодлогын үндсэн 9 чиглэлийг багтаасан таниулах сургалтыг зохион байгуулж төр, төсвийн нийт 22 байгууллагын 635 албан хаагчдыг хамрууллаа.

“Алсын хараа-2050” 5 төрлийн видео бичлэгийг Мандал сумын Засаг даргын Тамгын газрын цахим хаяг, Хэрх, Түнхэл тосгоны цахим хаягаар олон нийтэд хүргэж 3166 хандалтыг авч, байгууллагын мэдээллийн электрон самбарт 16 бичлэгийг байршуулан 10 хоногийн турш тогтмол сурталчлан таниуллаа.

Сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 2.1.3, 2.1.4 заалтад тусгагдсан дагуу “Эрүүл иргэн-2024” амны хөндийг эрүүлжүүлэх хөтөлбөрийн төсөл, “Чадварлаг эмч”, эмнэлгийн мэргэжилтэн хөтөлбөрийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлууллаа.

Сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл “Монгол өрх” ТББ-тай хамтран “Багийн хамтарсан баг”-ийн гишүүдийг чадавхжуулах зорилгоор “Кейс менежмент ба түүнийг шийдвэрлэх арга зам” сэдэвт сургалтыг зохион байгуулж хамтарсан багийн 46 гишүүдийг хамрууллаа.

Сумын Засаг даргын 2022 оны “Удирдах ажилтны Мэдээллийн цаг арга хэмжээ зохион байгуулах тухай” А/119 дүгээр захирамжийн хүрээнд Засаг даргын Тамгын газраас Монгол Улсын Хөдөлмөрийн баатар П.Цэрэндагва, Монгол Улсын Ардын жүжигчин Д.Мэндбаяр нарын “Гэр бүлийн үнэ цэнэ-Монгол хүний ёс жудаг” сэдэвт лекцийг 3 удаагийн давтамжтайгаар төрийн байгууллагын ажилтан, албан хаагч, ерөнхий боловсролын 11, 12 дугаар ангийн сурагчид, нийт 900 гаруй иргэдийг хамрууллаа.

Олон Улсын ахмадын баярын өдрийг тохиолдуулан нийт ахмад буурлууддаа хүндэтгэл үзүүлэх зорилгоор сумын Ахмадын хороотой хамтран Монгол Улсын Ардын жүжигчин С.Батсүх, Монгол Улсын гавьяат жүжигчин Э.Бүрнээбаяр нарын хамтарсан “Хүндэтгэлийн тоглолт”-ыг үнэ төлбөргүй зохион байгуулж 300 гаруй ахмадыг хамрууллаа.

Орчин цагийн боловсролын байгууллага үүсэж хөгжсөний 101, Монголын багш нарын 56 дахь өдрийг тохиолдуулан сумын боловсролын салбарын 16 байгууллагын 500 гаруй багш нарыг хамруулсан баярын хурал зохион байгуулж, арга хэмжээний үеэр Улс, Олон Улсын тэмцээнд амжилттай оролцсон багш болон элсэлтийн ерөнхий шалгалтад 800 оноо авч амжилт гаргасан сурагчдыг бэлтгэсэн

нийт 8 багш, Улсын багш нарын илтгэлийн уралдааны дэд байрын шагналт “Нэмэх цэнэг” багт мөнгөн урамшуулал олголоо.

Сумын Засаг даргын 2022 оны “Хуш модны самар бэлтгэх үйл ажиллагаанд хяналт тавих, байгаль орчны эсрэг гэмт хэрэг, зөрчил, болзошгүй аваар ослоос урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай” А/363 дугаар захирамжийн хүрээнд Барчулуут, Түнхэл чиглэлд хяналтын пост гарган, хуш модны самар бэлтгэн тээвэрлэх 13 аж ахуй нэгж байгууллагын 110 зил-131 маркийн автомашинтай гурвалсан гэрээ хийж ажиллаж байна.

Мод бэлтгэлийн талбай тусгаарлалт хийлгэх ажлын хүрээнд 4 аж ахуй нэгж байгууллага хүсэлт гаргасны дагуу үйлдвэрлэлийн огтлолтоор 34 га, цэвэрлэгээний огтлолтоор 25 га, цэвэрлэгээний ажлаар 13 га буюу нийт 6 цэгт 72 га талбайд тусгаарлалтын ажлыг хийж гүйцэтгэлээ.

Мод бэлтгэх эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээний олголтын хүрээнд 3 аж ахуй нэгж байгууллага 420 м3 хэрэглээ, 112 м3 түлээ, 11 нөхөрлөл, 3 аж ахуй нэгж байгууллагын эзэмшлийн ойн сангаас 92 иргэнд 450 м3 түлээний мод бэлтгэх эрхийн бичгийг тус тус олгож 9.7 сая төгрөгийг төрийн сангийн дансанд төвлөрүүлсэн. Мод бэлтгэх эрхийн бичгийг үндэслэн хэрэглээ 16 байгууллагад 663,5 м3, түлээ 117 м3, Улаанбаатар төмөр замын Мод бэлтгэх үйлдвэрт хэрэглээ 837,5 м3, түлээ 56 м3 нийт 1674 м3 модыг 68 ширхэг гарал үүслийн гэрчилгээгээр олгоод байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны “Мод тарих үндэсний өдөр зарлах тухай” 63 дугаар зарлиг, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, 2013 оны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 178 дугаар зарлиг хэрэгжилтийг ханган сумын хэмжээнд 100 аж ахуй нэгж байгууллагуудын 1048 иргэн 6 нэр төрлийн 8552 ширхэг мод тарьсан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Хүнсний хангамж-аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний нээлтийн хүрээнд “Сэлэнгэ-Алтан намар 2022” нэгдсэн арга хэмжээнд мод үржүүлгийн ажил эрхэлдэг 2 иргэн, 3 нөхөрлөл, 10 аж ахуй нэгж байгууллага, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч 4 иргэн, 3 хоршоо, 14 аж, ахуй нэгж 25 нэр төрлийн бүтээгдэхүүнээр оролцлоо.

Сумын Засаг даргын 2022 оны “2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай” 01 тоот албан даалгаврын хэрэгжилтийг хүрээнд айл, өрхийн түлшний хэрэгцээг хангах зорилгоор 35 мэргэжлийн байгууллагад үүрэг өгсний дагуу сумын төвд 7 байгууллага 501м, Түнхэл тосгонд 6 байгууллага 227м3 буюу нийт 727,6 м3 түлшний модыг доод агуулахад татан төвлөрүүллээ.

Сумын хэмжээнд 37 аж ахуй нэгж байгууллага, 1053 өрх газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлж, үр тариа 4850,3 га талбайгаас 5987тн, тэжээлийн ургамал 840,7 га талбайгаас 3549,5 тн, техникийн ургамал 444 га талбайгаас 213 тн, төмс 713,8 га талбайгаас 7360 тн, хүнсний ногоо 1170,6 га талбайгаас 20700 тн ургац хураан авлаа.

Сумын Засаг даргын 2022 оны “Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтай дархлаажуулах ажлыг зохион байгуулах тухай” А/379 тоот захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 670 өрхийн 7500 үхэр, 570 гахайг хамрууллаа.

Малчин, мал бүхий 105 өрхтэй 3633.9 га талбай ашиглах гэрээг байгуулж сумын өвс, тэжээлийн аюулгүй нөөцийг бүрдүүлэх зорилгоор 2770 боодол өвсийг нөөцлөөд байна.

Сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.4.1 дэх заалтад тусгагдсан бүтээн байгуулалтын ажлын хүрээнд орон нутгийн санхүүжилтээр хийгдэх сум доторх хатуу хучилттай 1,7 км зам засварын ажил бүрэн хийгдэж дууслаа.

Орхон сум:

Аймгийн Засаг даргын 2022 оны “Хугацаат цэргийн албаны ээлжит татлага зохион байгуулах тухай” А/390 дүгээр захирамжийн хүрээнд Сайхан суманд зохион байгуулагдсан “Цэргийн жинхэнэ албаны татлага”-д сумын хэмжээнд 60 хүүхдэд зарлан дуудах мэдэгдэл өгснөөс 25 хүүхдийг үзлэгт хамрууллаа.

Мал амьтны гоц халдварт шүлхий /А01/ өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг эхлүүлж 10 дугаар сарын байдлаар 259 өрхийн 13340 үхэр, 97 гахайнд урьдчилан сэргийлэх тарилгыг хийгээд байна.

Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал”-аар тус суманд 5 га талбайд ногоон зурвас байгуулах ажлыг “Агро Форест” ХХК зохион байгуулж, шинэс, агч, хайлаас, бургас зэрэг 5000 ширхэг суулгацыг тарьж хашаажууллаа.

Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын нутаг дэвсгэрээс зөвшөөрөлгүй хуш модны самар бэлтгэж, тээвэрлэсэн, гарал үүслийн хугацаа нь дууссан гэх зөрчил гаргасан Орхон аймгийн харьяат 1 иргэнд 500.000 төгрөг, Баруунбүрэн, Сайхан сумын харьяат 2 иргэнд тус бүр 300.000 төгрөг, зөвшөөрөлгүй газар ашиглаж, хадлан бэлтгэсэн Орхон сумын харьяат 1 иргэнд 500.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээг Зөрчлийн тухай хуулийн дагуу тус тус тооцлоо.

Сумын Засаг даргын 2022 оны “Тариалангийн талбай, өвөлжөөний газрыг малын хөлөөс чөлөөлөх тухай” А/43 тоот захирамжийг хэрэгжүүлээгүй тус сумын харьяат 2 иргэнд тус бүр 100.000 төгрөгийн торгуулийг Зөрчлийн хуулийн дагуу тооцож ажиллалаа.

Улаанбуудайн үрд 425 тн нөөцөлж, ХААДС-д 942 тн, гурилын үйлдвэрт 3965 тн, спиртийн үйлдвэрт 240 тн, тэжээлд 95 тн-ыг тус тус борлууллаа.

Тарималын төрөл	Тариалсан талбай /га/	Хураасан талбай /га/	Хураасан ургац /тн/	Га-ийн ургац /тн/	Ургац алдсан талбай/га/	Хураалтын явц
Улаан буудай	7760	7760	7465	9		100
Овьёос	275	275	265	9		100
Тосны ургамал	5183	5083	1497	3	100	100
Тэжээлийн ургамал	340	340	362	10,4		100
Төмс	5,5	505,5	6571,5	130		100
Хүнсний ногоо	456,3	443,7	5729,5	140,3	13	100
Бэлтгэсэн уринш	11716					

/Ургац хураалтын мэдээ/

Орхонтуул сум:

Аймгийн Засаг даргын 2022 оны А/390, сумын Засаг даргын А/124 дүгээр захирамжийн хүрээнд 2022 оны хугацаат цэрэг татлагыг зохион байгуулж, сумын хэмжээнд 13 цэрэг эрүүл мэндийн үзлэгт тэнцлээ.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж буй Баянцогт 2-р багийн орон сууцны дээврийн засварын /2 орц/ ажлын гүйцэтгэл 70 хувьтай байна. Мөн Рашаант тосгонд гэрэлтүүлэг нэмэгдүүлэх, аймгийн Замын сангийн хөрөнгөөр “Орхонтуул сумын зам засвар, тэмдэг тэмдэглэгээ, замын гэрэлтүүлэг”, “Рашаант тосгоны зам засвар, тэмдэг тэмдэглэгээ, замын гэрэлтүүлэг”, ажлын гүйцэтгэл 90 хувьтай байна.

Малын эрүүл мэндийг хамгаалах халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малчдад зориулсан сургалт сурталчилгаа, тоног төхөөрөмж худалдан авах арга хэмжээ 100 хувь хийгдэж, тоног төхөөрөмжүүдийг хүлээн аваад байна.

“Сэлэнгэ Алтан намар-2022” үзэсгэлэн худалдаанд эсгий туурга, зөгийн бал, сүү цагаан идээ, хүнсний ногооны төрлөөр оролцож, 1.735,000 төгрөгийн борлуулалт хийсэн байна.

Улсын Онцгой комиссын 2022 оны “Мал амьтны гоц халдварт өвчний талаар авах зарим арга хэмжээний тухай” 02 дугаар тогтоол, “Үүрэг хүргүүлэх тухай” 330 дугаар албан тоот, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2022 оны А/191 тоот тушаал, аймгийн Засаг даргын 2022 оны А/388 тоот захирамж, сумын Засаг даргын 2022 оны А/132 тоот захирамжийн дагуу мал, амьтныг гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтай дархлаажуулалтын ажлыг зохион байгуулж 350 өрхийн 22000 толгой үхэр хамруулаад байна.

Сайхан сум:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд “Ногоон ирээдүйг бүтээцгээе” уриантай нээлттэй өдөрлөг зохион байгуулж мод тарих аргачлал, зөвлөмж, гарын авлага мөн 1 өрхөд 4 төрлийн суулгацаас тус бүр 2 ширхэг нийт 8 ширхэг тарьц, суулгацыг үнэгүй тараасан.

Аймгийн Засаг даргын А/402 тоот захирамжийн дагуу сумын нийт ахмадуудад хүндэтгэл үзүүлж “Ахмадын баяр-2022” арга хэмжээг зохион байгууллаа.

Дэлхийн багш нарын баярыг тохиолдуулан сумын нийт багш нарын баярын арга хэмжээг зохион байгуулсан.

Сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид, ажлын албатай хамтран сумын 1,2-р сургуулийн сурагчдын дунд сургалт, АХА тэмцээн, шатрын тэмцээнийг зохион байгууллаа.

“Сэлэнгэ-Алтан намар 2022” нэгдсэн арга хэмжээнд Сайхан сумаас хүнсний хангамжийг бүрдүүлэгч хүнсний ногоо, жижиг дунд үйлдвэрлэл, өрхийн аж ахуй эрхлэгч, тарьц суулгац тариалагч, баялаг бүтээгч нийт 5 аж ахуйн нэгж, иргэд оролцлоо

Сумын өнгө үзэмж, иргэдийн ая тухтай байдлыг хангах зорилгоор 7-р байрны ар талаар сумын Эрүүл мэндийн төв рүү “Тохилог орчин” явган хүний зам засах нийтийг хамарсан ажлыг хийж гүйцэтгэлээ.

“Хөдөлмөрийн бүтээмж-2022” үзэсгэлэн худалдаанд төсөл хөтөлбөрт хамрагдсан нийт 4 иргэн болон борлуулалтын лангуугаар дамжуулан борлуулалт хийж байгаа “Сайханд үйлдвэрлэв” иргэдийн бараа бүтээгдэхүүнээр үзэсгэлэн гаргаж борлуулалт хийж оролцлоо.

Бог малын зохиомол хээлтүүлгийн ажлыг сумын хэмжээнд нийт 950 хонинд хийгдлээ.

Сант сум:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 63 дугаар зарлиг "Мод тарих үндэсний өдөр", "Тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөн"-ий хүрээнд "Бидний тарих тэрбум мод, таны тарих нэг модноос эхэлнэ" уриантай сумын төр төсвийн байгууллагууд, өрх иргэд мод тарьж ногоон байгууламжаа нэмэгдүүллээ. Төсвийн 5 байгууллага 9 төрлийн 445 ширхэг мод тарьж 2.545.000 төгрөг зарцуулагдсан байна.

Сумын өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд 380 өрхөд 2354 м3 түлээ, 74 иргэнд 298 м3 хэрэглээний мод бэлтгэх эрхийн бичиг олгож, иргэдийн түлээ бэлтгэл 75 хувьтай явагдаж байна.

Газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж зөвшөөрөлгүй газар ашигласан, хадлан тариаланд мал оруулсан гэх 4 зөрчлийг шалган шийдвэрлэж, хялбаршуулах аргаар 4 иргэнд 1300.000 төгрөгийн торгох шийтгэл оногдуулсан. Бусдад учруулсан 2.200,000 төгрөгийн хохирол, 100.000 төгрөгийн торгуулийг барагдуулж ажиллалаа.

Сумын хэмжээнд “Хоггүй цэвэр орчин” уриантай бүх нийтийн хог цэвэрлэгээг зохион байгуулж, төсвийн 5 байгууллагын 70 гаруй ажилтан албан хаагч нийтийн эзэмшлийн талбай болон төвлөрсөн хогийн цэгийн хог хаягдлыг цэвэрлэж 14 м3 хогийг тээвэрлэн хаясан.

Аймгийн Засаг даргын 2022 оны А/390 дүгээр захирамжийн дагуу 2022 оны хоёрдугаар ээлжийн цэрэг татлагыг зохион байгуулж, 36 залуус хамрагдаж 7 иргэн эрүүл мэндийн үзлэгт тэнцэн цэргийн албанд татагдсан.

Аймгийн Засаг даргын 2022 оны А/402 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж Ахмадын хороотой хамтран “Ахмадын баяр”-ын өдрийг сумын хэмжээнд тэмдэглэн өнгөрүүллээ. Ахмадын байрны нээлт, хүндэтгэлийн хүлээн авалтын арга хэмжээнд нийт 180 гаруй ахмад настан хамрагдаж, суманд харьяалалтай 53 аж ахуйн нэгж, байгууллага гарын бэлэг гардууллаа. Тус арга хэмжээгээр

- “Хөдөө аж ахуйн салбарын тэргүүний ажилтан” тэмдэгээр 3 ахмад настан,
- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Хүндэт өргөмжлөл”-өөр 2,
- Аймгийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр 2,
- Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Өргөмжлөл”-өөр 3,
- Сумын Засаг даргын “Жуух бичиг”-ээр 2 ахмад настан шагнагдлаа.

Сүхбаатар сум:

Аймгийн Засаг даргын 2021 оны “Хөтөлбөр хэрэгжүүлэх, Шударга-Удирдагч, Шударга-төрийн албан хаагч аян зохион байгуулах тухай” А/292 дугаар захирамжийн хүрээнд тус сумын харьяа ерөнхий боловсролын 7 сургууль, 8 цэцэрлэгүүдийн дунд зохион байгуулж, аяны дарцаг тугийг ерөнхий боловсролын 1-р дүгээр сургуульд гардуулан өглөө.

Аяны хүрээнд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн удирдлагууд, 8 багийн Засаг дарга, мэргэжилтнүүдэд Авлигын эсрэг хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах хуулиар сургалт хийж, 24 албан хаагч хамрагдсан.

Сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг 2022 онд хэрэгжүүлэх ажил арга хэмжээний төлөвлөгөөний дагуу “Суралцагч байгууллага аян”ийг 2022 оны 09 дүгээр сарын 20-ны өдрөөс 2022 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн хугацаанд тус сумын Засаг даргын Тамгын газар болон харьяа төр төсвийн байгууллагуудын дунд зохион байгуулж байна. Аяны хүрээнд албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх, идэвх санаачилгатай, ёс зүйтэй бөгөөд төрийн албан хаагч, суралцагч байгууллага бүхий төрийн албыг төлөвшүүлэхэд анхаарч дотоодын сургалтын үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж байна.

Аймгийн Засаг даргын 2022 оны “Хугацаат цэргийн албаны ээлжит татлага зохион байгуулах тухай” А/390 дүгээр захирамжийн хүрээнд 2022 оны хоёрдугаар ээлжийн хугацаат цэрэг татлагыг зохион байгуулж, Сүхбаатар, Шаамар, Зүүнбүрэн, Түшиг, Алтанбулаг, Цагааннуур сумын 1996-2004 оны хооронд төрсөн хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтэн залуучууд хамрагдлаа.

Олон Улсын Ахмадын өдрийн хүрээнд Сүхбаатар сумын Засаг даргын Тамгын газар, сумын “Хөршөө хайрлая” ахмадын хороо хамтран “Ахмадын баярын хүндэтгэлийн тоглолт” арга хэмжээг зохион байгуулж, сум орон нутагтаа олон жил үр бүтээлтэй ажиллаж, хөдөлмөрлөсөн 200 гаруй ахмад настан хамрагдсан.

Мөн ахмадын баярын өдрийг тохиолдуулан ахмад буурлууддаа хүндэтгэл үзүүлэх, Монгол үндэстний урлагийн их өв санг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, тэдний авьяас чадварыг хөгжүүлэх, ахмадуудын нийгмийн идэвх, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор 8 багийн Засаг дарга нар багийн ахмад настууддаа хүндэтгэл үзүүлэн хүлээн авч урлаг спортын арга хэмжээг зохион байгуулж, 400 гаруй ахмад настан хамрагдсан.

Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх ажлын хүрээнд аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран “Гэр бүл төлөвлөлт”, “Гэр бүл хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтад давхардсан тоогоор 136 иргэнийг хамрууллаа.

Сумын Засаг даргын Тамгын газар, “Эмнэх баг” өрхийн эрүүл мэндийн төв, “Сэлэнгэ амьдрах сайхан” ТББ хамтран “Эерэг хандлага-Эрүүл байхын үндэс” өдөрлөгийг зохион байгуулж, зорилтот өрхийн 15 иргэн, архины хамааралтай 10 иргэнд сэтгэл зүйч Г.Болорцэцэг “Гэр бүлийн харилцаа”, Гэр бүлийн хүчирхийллийн тухай хуулиар, Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нар “Эрүүл зөв хооллолт идэвхтэй хөдөлгөөн” сэдвээр, “Сэлэнгэ амьдрах сайхан” ТББ “Харилцаа хандлага, хорт зуршил амьдралд нөлөөлөх нь” сэдвээр сургалт, ярилцлага өрнүүллээ.

Сумын хэмжээнд 2022 оны байдлаар 283 өрх, 2 аж ахуйн нэгж 72 га-д төмс, хүнсний ногоо 48 га-д тариалсан. 10 дугаар сарын байдлаар төмс 565.2 тн, хүнсний ногоо 479.5 тн тус тус хураан аваад байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Хүнсний хангамж-аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний нээлтийн хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газар, аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газар хамтран “Сэлэнгэ-Алтан намар-2022” нэгдсэн арга хэмжээнд сумын хүнсний хангамжийг бүрдүүлэгч хүнсний ногоо, жижиг, дунд үйлдвэрлэл, өрхийн аж ахуй эрхлэгч, тарьц суулгац тариалагч 23 иргэн оролцож 7.250,000 төгрөгийн борлуулалт хийсэн.

Сумын Засаг даргын Тамгын газар аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газартай хамтран “Залуу малчин-2022” уулзалт зөвлөгөөн, сүү

цагаан идээний үзэсгэлэн худалдааг зохион байгууллаа. Үзэсгэлэн худалдаанд хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангаас олгогддог санхүүгийн дэмжлэгт хамрагдсан тус сумын 3 иргэн оролцлоо.

Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, сумын Засаг даргын Тамгын газар хамтран “Хөдөлмөрийн бүтээмж-2022” үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, төмс хүнсний ногоо тариалан эрхлэгч 9 иргэн 1.450,000, жижиг дунд үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгч 10 иргэн 3.450,000 төгрөгийн борлуулалт хийсэн байна.

Сумын Засаг даргын 2022 оны “Малын шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтай дархлаажуулалт зохион байгуулах тухай” А/264 дүгээр захирамжийн дагуу малын шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтай дархлаажуулалтыг сумын хэмжээнд 120 гахай, 4775 үхэрт хийгээд байна.

Аймгийн Засаг даргын 2022 оны “Малд үзлэг ангилалт хийх тухай” А/168, сумын Засаг даргын 2022 оны “Малын үзлэг ангилалт хийх ажлын хэсэг байгуулах тухай” А/264 тоот захирамжийн дагуу сумын хэмжээнд малд үзлэг ангилалт хийх ажлыг зохион байгуулж, 10 дугаар сарын байдлаар 2 багийн 8 өрхийн 42 толгой үхэрт үзлэг ангилалт хийгээд байна.

Аймгийн Засаг даргын 2022 оны “2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай” 02 дугаар албан даалгаврын хүрээнд тус сумын хэмжээнд хадлан 2083 тн, үйлдвэрийн тэжээл 741 тн, давс, хужир, шүү 93 тн хэрэгцээтэй бөгөөд хэрэгцээт хадланг Шаамар, Алтанбулаг, Зүүнбүрэн сумдын нутаг дэвсгэрээс нийт 2095 тн байгалийн хадлан бэлтгэсэн байна.

Мөн үйлдвэрийн тэжээл 582 тн, давс хужир шүү 62 тн бэлтгэсэн ба сумын малчид, мал бүхий иргэдийн 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл хангалт 96,9 хувийн биелэлттэй байна.

“ТЭРБУМ МОД” үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлэх аймгийн засаг даргын “Бүх нийтээр мод тарих өдрийг зохион байгуулах тухай” А/380 захирамжийн хүрээнд сумын Засаг даргын Тамгын газар, “Цагаан эрэг тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг хамтран нийтийн эзэмшлийн зам талбайд 90 нарс 90 голт бор тарьж өвлийн унтуулгад бэлдэн ажилласан.

Мөн Монгол Улсын Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны 09 дүгээр сарын 28-ний өдрийн “Бүх нийтээр мод тарих сарын ажлыг зохион байгуулах тухай” 12 тоот албан даалгавар, аймгийн Засаг даргын “Бүх нийтээр мод тарих өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай” 2022 оны А/380 тоот захирамжийн хүрээнд “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг орон нутагт эрчимжүүлж, иргэд олон нийтийг татан оролцуулах ажлын цар хүрээг нэмэгдүүлэх зорилгоор тус сумын хэмжээнд “Бүх нийтээр мод тарих арга хэмжээ”-г зохион байгуулж, 48 өрх 327 ширхэг модыг хашаандаа, 73 аж ахуй нэгж байгууллага 2189 ширхэг модыг орчин тойрон бичил цэцэрлэгт хүрээлэнд, байгуулсан цэцгийн мандал 205 м², төв суурин газар тарьсан модны тоо 2516, Ойн зурваст тарьсан модны тоо 4000, нийт сумын хэмжээнд 6516 ширхэг модыг тарьж өвлийн унтуулгад бэлтгэн ажиллалаа.

Орхон аймагт зохион байгуулагдсан “Үндэсний аварга шалгаруулах үсчин, гоо засалч, хумс дизайн урлалын 25 дугаар их наадам”-д тус сумын 8 үсчин, гоо засалчид оролцож, “Эрэгтэй зураглалтай засалтын төрөл”-д Б.Анхзаяа “Мөнгөн медаль”, “Эмэгтэй креатив хэлбэржүүлэлтийн төрөл”-д Д.Батсүрэн “Мөнгөн

медаль”, “Бие дээрх уран зураглалын төрөл”-д Б.Үүрийнтуяа тусгай байрын шагналыг тус тус хүртлээ.

Түшиг сум:

Сумын хэмжээнд Ахмадын баярыг нийт ахмадууддаа хүндэтгэл үзүүлэн Хүндэтгэлийн хурлын үйл ажиллагаагаар нээж, улс орон сум орон нутгийнхаа хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулж буй зарим ахмадуудаа шагнаж урамшууллаа. Мөн ахмадуудыг дунд спортын тэмцээн уралдааныг зохион байгуулж, 52 ахмад хамрагдлаа.

Дэлхийн багш нарын 28, Монголын багш нарын 56 дахь өдрийг тохиолдуулан эрхэлсэн ажилдаа амжилт гарган ажиллаж буй боловсролын байгууллагын дараах багш, ажилчдыг сумын Засаг даргын “Жуух бичиг”-ээр шагналаа.

- Цэцэрлэгийн багш Б.Баярцэцэг
- Ерөнхий боловсролын сургуулийн мэдээлэл зүйн багш Ч.Ганцэцэг
- Ерөнхий боловсролын сургуулийн номын санч А.Энхчимэг
- Ерөнхий боловсролын сургуулийн үйлчилгээний ажилтан Б.Урантогос

Сумын хэмжээнд үр тарианы хураалт 75 хувьтай буюу 4043 га талбайд хураалт хийсэн. Үүнд:

- Үр тариа 11,5 цн буюу 4675 тн
- Улаанбуудай-3295 га талбайгаас хураалт хийснээс
- Тэжээлийн ургамал 862 га талбайгаас 1610 тн
- Рапс 2094 га талбайгаас 1011 тн тус тус хураан аваад байна.

Нийт 3802 тн өвс бэлтгэх төлөвтэйгөөс 10 дугаар сарын байдлаар 7010 тн өвс бэлтгээд байна. Сумын хэмжээнд 129 малчин, 227 мал бүхий өрх, 7 аж ахуйн нэгжид 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл ажлаа хангаад байна.

Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад 1 аж ахуй нэгж, 196 өрхийн 11299 толгой үхэрт, 106 өрхийн 40251 толгой бог, гахай 102 толгой гахай нийт 51550 толгой мал тус тус хамруулсан. Тарилга хийхэд нийт 22598 бодод 22,6 тун тарилга, 40521 богд 40,5 тун тарилга, 102 гахайд, 204 тун тарилга зарцуулсан.

“ММЭ Түшиг” ХХК, “Мойлт нуга” ХХК-ий 3 талбайд мод бэлтгэл болон гарал үүслийн гэрчилгээгээр гадагш тээвэрлэж байгаа модонд хяналт тавьж эрхийн бичиг, гарал үүслийг хянаж ажиллалаа.

БОАЖС-ын 2020 оны А/372 тоот тушаалын дагуу суманд 332 тн хуш модны самрыг үйлдвэрлэлийн зориулалтаар зөвшөөрлийн дагуу ойн дагалт баялаг ашиглах эрх бүхий мэргэжлийн 7 тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжтэй үйлдвэрлэлийн зориулалтаар хуш модны самар түүж бэлтгүүлэхээр гэрээ хийж, хяналт тавин ажиллаж байна. 10 дугаар сарын байдлаар 129,7 кг самрыг эрх бүхий аж ахуйн нэгжүүд тээвэрлээд байна.

Хушаат сум:

Монгол Улсын “Алсын хараа-2050” бодлогын баримт бичгийг сурталчлах ажлын хүрээнд уг баримт бичгийг цахим хэлбэрээр сумын сайтад байршуулж баримт бичгийн зорилго, агуулгын талаарх товч танилцуулгыг бэлтгэн сумын төр, төсвийн байгууллагуудын цахим хаягаар иргэдэд сурталчлан ажиллаж байна.

Аймгийн хөрөнгө оруулалтаар Ахуйн үйлчилгээний их засварын ажил өнөөдрийн байдлаар 80 хувьтай, төв замын засвар, тэмдэг тэмдэглэгээний 50.0 сая төгрөгийн ажил 100 хувь гүйцэтгэж дууссан.

Дархан, Сэлэнгийн замтай холбох төв замын зураг төсөв боловсруулах 80 сая төгрөгийн ажлын гүйцэтгэл 100 хувьтай дуусаж сумын удирдлагууд хүлээн аваад байна.

Мөн сумын орон нутгийн хөгжлийн сангийн малын тоо толгойн албан татварын орлогын хөрөнгөөр хийгдэхээр гэрээ байгуулсан 4 ажлаас 3 ажил болох Булаг, шандын эх хамгаалах, Хэсгийн цагдааг унаажуулах, Малын халдварт өвчинтэй тэмцэх зардал зэрэг ажил нь 100 хувь, Зуслангийн зам даваа засварын ажил 80 хувьтай байна.

Ахмадын баярыг сумын хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлж, арга хэмжээнд 70 гаруй ахмад настан оролцсон. Уг арга хэмжээний үеэр

- “Ардын хувьсгалын 100 жилийн ойн медаль”-аар 10 ахмадыг,
- Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Хүндэт өргөмжлөл”-өөр 3 ахмад төрийн албан хаагчийг,
- “Худалдааны 100 жилийн ойн медаль”-аар 2 ахмадыг,
- Ахмадын хорооны “Хүндэт өргөмжлөл”-өөр 2 ахмадыг тус тус шагнаж урамшууллаа.

“Намрын өгөөж-Ахмадын хишиг” үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, 11 иргэн хүнсний ногоо, сүүн бүтээгдэхүүнээ худалдан борлууллаа.

Сумын “Нийгмийн хамгаалал ба нийгмийн бодлого” группд 4 төрлийн мэдээлэл тавьж давхардсан тоогоор 95 иргэн үзэж судлан танилцсан байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Хүнсний хангамж-аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний нээлтийн хүрээнд “Сэлэнгэ-Алтан намар 2022” нэгдсэн арга хэмжээнд тус сумын иргэн Н.Оюунцэцэг, Н.Оюунчимэг нар даршилсан ногоо, жимс жимсгэнээр “Элит үр” ХХК төмс, хүнсний ногоогоор оролцож “Сэлэнгэ-5” шинэ сортын үрийн төмсөөр “Шилдэг ногоочин”-оор шагнагдлаа.

Мөн Хушаат суманд 3,0 сая төгрөгийн үнэ бүхий хүлэмж бэлэглэж уг үзэсгэлэн худалдаанд идэвхтэй оролцсон ногоочин Н.Оюунцэцэгт хүлээлгэн өглөө.

Хүдэр сум:

Сумын хэмжээнд 394 малчин, мал бүхий өрх, 2 аж ахуйн нэгжийн нийт 47347 толгой мал өвөлжих төлөвтэй байна. Үүнд адуу 5067, үхэр 13820, хонь 15346, ямаа 13114 толгой тус тус байна. Малчид 5000 тн хадлан, 10 тн ногоон тэжээлийг бэлтгэсэн.

“Хүдэр Дулаан” ХХК 10 дугаар сарын байдлаар 130 тн нүүрсний захиалгыг өгч татан авалтыг хийж байна.

Сумын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй дулааны тоолуур тавих ажлыг Улаанбаатар хотын “Ультрасоник” ХХК гүйцэтгэн төр төсвийн 5 байгууллагад суурилуулах ажлыг хийж гүйцэтгэсэн.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар гэр хорооллуудын дундах хайрган хучилттай 320 сая төгрөгийн зам засвар, 45 сая төгрөгийн шинэ суурьшлын бүсэд худаг гаргах хөрөнгө оруулалтын 2 ажил 70-90 хувийн гүйцэтгэлтэй байна. Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн сайдын 2022

оны А/68 тоот тушаал, аймгийн Засаг даргын 2022 оны А/168 тоот захирамжийн дагуу Сумын хэмжээнд “Их цагааны рашаан” ХХК-тай хамтран тус сумын нутагт үржүүлж байгаа 2300 малд үзлэг ангилалт, ашиг шимийг тодорхойлох баталгаажуулах, мэдээллийн санд бүртгүүлэх ажлыг зохион байгуулан ажилласан.

Суманд нийт 6149 га газар үр тариа болон тэжээлийн ургамал тарьсан, 10 дугаар сарын байдлаар үр тариан ургац хураалт 53,4 хувь, Тэжээлийн ургамал 100 хувь, Төмс 68 га-д, хүнсний ногоо 46 га-д тариалалт хийсэн ургац хураалт 100 хувь дууссан байна.

Үтрэмд нийт 5005 тн будаа 250 тн тосны ургамал буусан үүнээс борлуулалтад “Шанд ургац” ХХК 300 тн будаа “Ургац хүдэр” ХХК 46 тн будаа ТЭДС-нд борлуулсан байна.

Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн салбарын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжих, үндэсний үйлдвэрлэлийн шилдэг бүтээгдэхүүн, шинэ ургацын дээжийг нэг дороос, үйлдвэрийн үнээр хүргэх зорилгоор “Сэлэнгэ-Алтан намар-2022” нэгдсэн арга хэмжээнд Хүдэр сумаас 4 иргэн буриад талх, даршилсан ногоо, хүнсний ногоо, хуш модны самар, цагаан идээ зэрэг бүтээгдэхүүнээр оролцож 1.300,000 мянган төгрөгийн борлуулалтыг хийж өрхийн орлогыг нэмэгдүүлсэн.

Цагааннуур сум:

Сумын хэмжээнд Олон Улсын "Ахмадын баяр"-ын өдрийг тэмдэглэн өнгөрүүлж, энэ үеэр төрийн дээд одон медаль “Алтан гадас” одонгоор С.Энхтуяа, аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр Д.Уранчимэг, аймгийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр Р.Лхагвасүрэн, сумын “Засаг даргын жуух бичиг”-ээр Ё.Оюун нар шагнагдсаныг сумын удирдлагууд гардуулан өгсөн.

Мөн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газраас ахмадын байрны ая тухыг хангах, ахмадын хорооны үйл ажиллагааг дэмжих зорилгоор 1.0 сая төгрөгийн үнэ бүхий хөргөгч гардуулан өглөө.

Сумын Засаг даргын 2022 оны “Бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгуулах тухай” А/116 дугаар захирамжийн дагуу иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд сумын төв доторх хогийг цэвэрлэж нийт 20 тн хогийг хогийн нэгдсэн цэгт буулгасан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Хүнсний хангамж-Аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний нээлтийн хүрээнд “Сэлэнгэ Алтан намар-2022” нэгдсэн арга хэмжээнд сумын жижиг дунд үйлдвэрлэл, өрхийн аж ахуй эрхлэгч 6 иргэн 5 төрлийн бүтээгдэхүүнээр оролцож 3.0 сая төгрөгийн борлуулалт хийсэн.

Сумын Улаан загалмайн анхан шатны хорооноос “Гамшгийн эрсдэлийг бууруулах олон улсын өдөр”-т зориулан гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог дэмжин идэвхжүүлэх, хамтран ажиллах “Бэлэн бай” сургалт зохион байгуулж 15 иргэн хамрагдсан.

“МОНГОЛ ВИ.И.ТИ.НЕТ” ТББ болон Н.Баярмагнай захиралтай "Таван-Эрдэнэ" мал эмнэлэг хамтран "Хайрын бэлэг" төслийн хүрээнд 15 зорилтод өрхөд тус бүр 1 хонь хандивласан.

Дэлхийн багш нарын 28, Монголын багш нарын 56 дахь удаагийн баярын өдрийг тохиолдуулан боловсролын салбарт олон жил, үр бүтээлтэй ажиллаж шагнагдсан багш нарын шагналыг гардуулан өгсөн.

БНСУ-ын Жежү тусгай мужийн Боловсролын газар, аймгийн БШУГ-ын хамтын ажиллагааны хүрээнд сумын ерөнхий боловсролын сургуульд мэдээлэл зүйн иж бүрэн танхимыг тохижуулан хүлээлгэн өглөө.

Сумын орон нутгийн хөгжлийн сангийн 80.0 сая төгрөгийн хөрөнгөөр санхүүжигдэж буй “Сити” нойлын барилгын ажил 50 хувьтай, сумын Засаг даргын Тамгын газрын барилгын урсгал засварын ажил 70 хувийн гүйцэтгэлтэй байна.

Сумын хэмжээнд улаанбуудай 21018 га талбайгаас 2590 тн, овьёос 390 га талбайгаас 351,3 тн, тэжээлийн ургамал 564 га талбайгаас 1128 тн, тосны ургамал 4242 га талбайгаас 1815 тн, төмс 40,26 га талбайгаас 860,28 тн, хүнсний ногоо 20,21 га талбайгаас 175,3 тн ургац хураан авч нийт ургац хураалт 62,7 хувьтай үргэлжилж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд аймгийн Засаг даргын 2022 оны "Бүх нийтээр мод тарих арга хэмжээг зохион байгуулах тухай" А/380 дугаар захирамжийн дагуу төр, төсвийн байгууллагын 32 албан хаагч Хуурч 2 дугаар багийн автозам дагуу 56 ширхэг нарс, 40 ширхэг шар хуайс тарьсан.

Шаамар сум:

Аймгийн Засаг даргын 2022 оны А/390 дүгээр захирамжийн дагуу сумын Засаг даргын “Хугацаат цэргийн албаны ээлжит татлага зохион байгуулах тухай” А/156 дугаар захирамжийн дагуу сумын 9 залуучууд эр цэргийн албанд татагдлаа.

Аймгийн Засаг даргын 2022 оны А/388 дугаар захирамжийн дагуу сумын Засаг даргын “Дархлаажуулалтын ажлын хэсэг байгуулах тухай” А/158 дугаар захирамжаар Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын 3 ажлын хэсэг 17 албан хаагч ажиллаж 253 малчин өрхийн 7252 үхэр, 191 гахайг дархлаажуулалтад хамруулсан байна.

Сумын Засаг даргын ивээл дор Олон Улсын Ахмадын баярын "АХМАДАА ХҮНДЭТГЭЭ" нэгдсэн арга хэмжээ зохион байгуулагдлаа.

Дэлхийн багш нарын 28 дахь, Монголын багш нарын 56 дахь удаагийн баярын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэв. Сумын хэмжээнд 2022-2023 оны хичээлийн жилд боловсролын 6 байгууллага сургалтын үйл ажиллагаа явуулсан бөгөөд эдгээрт нийт 191 багш, ажиллагчид ажилласан байна.

Сэлэнгэ аймаг дах Тагнуулын газраас “Төрийн болон албаны нууцын ашиглалт, хамгаалалт”, “Терроризомтой тэмцэх, урьдчилан сэргийлэх” сэдвээр сургалтыг зохион байгуулж төр, төсвийн байгууллагын албан хаагчдыг бүрэн хамруулж ажиллалаа.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын зорилго, зорилт, үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар сургалтыг зохион байгууллаа. Сургалтад нийт 30 албан хаагч хамрагдаж цаашид “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хэрэгжилтийн явцын талаар иргэд, олон нийтэд таниулах ажлыг зохион байгуулахаар төлөвлөж байна.

Монгол Улсын Ойн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны “Мод тарих үндэсний өдөр зарлах тухай” 63 дугаар зарлиг аймгийн Засаг даргын 2022 оны А/380 дугаар захирамжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд гарсан бүх нийтээр мод тарих өдрийг сумын хэмжээнд зохион байгуулж Соёлын төвтэй хамтран “Үндэсний өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх

талаар аж ахуй нэгж албан байгууллагууд, иргэд олон нийтэд цахимаар сурталчилж, сумын зарын нэгдсэн групп “Бид Шаамарынхан” цахим хуудсанд зурагт хуудас бүхий зөвлөмж уриалга, шторкийг байршуулж ажилласан.

“Сэлэнгэ-Алтан намар 2022” нэгдсэн арга хэмжээнд аж ахуйн нэгж, иргэдээ удирдан зохион байгуулж, идэвх зүтгэлтэй оролцож “Зохион байгуулалттай шилдэг сум”-аар шалгарав.

ХЯНАСАН:
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА Ө.СУВДАА

НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИДЛАГЫН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН Д.АЛТАНТУЯА